



Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: ТӨМӨР ЗАМЫН ДЭЭД СУРГУУЛЬ

Сургалтын хөтөлбөрийн нэр: ЗҮТГҮҮРИЙН АЖ АХУЙ

Индекс: D104101

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Баатархүү

Гишүүд: С.Ариунбаяр

Т.Мөнхцэцэг

Он сар өдөр: 2019.05.02-03

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт	4
II. Сургалтын хөтөлбөрийн ТАНИЛЦУУЛГА	5
III. Мэргэжлийн зөвлөлийн тодорхойлолт	Error! Bookmark not defined.
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	7
1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага	7
1.2. Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго	7
1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд	8
Шалгуур 2. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	9
2.1. Сургалтын орчин	Error! Bookmark not defined.
2.2. Сургалтын хэрэглэгдэхүүн	Error! Bookmark not defined.
2.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр	Error! Bookmark not defined.
Шалгуур 3. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	22
3.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа	22
3.2. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт	23
3.3. Төгсөлтийн дараах бодлого	23
3.4. Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа	24
3.5. Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ	25
3.6. Санхүүжилт	Error! Bookmark not defined.
Шалгуур 4. Суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа	25
4.1. Суралцагч сонгох, элсүүлэх	Error! Bookmark not defined.
4.2. Зөвлөх, туслах үйлчилгээ	Error! Bookmark not defined.
4.3. Оюутны байгууллагад үзүүлдэг дэмжлэг	Error! Bookmark not defined.
4.4. Суралцагчийн урамшууллын тогтолцоо	Error! Bookmark not defined.
4.5. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн	Error! Bookmark not defined.
Шалгуур 5. Багшийн үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.

5.1. Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого	Error!
Bookmark not defined.	
5.2. БАГШИЙН ХӨГЖИЛ	35
5.3. Эрдэм шинжилгээ, судалгаа	36
5.4. Багшийн үнэлгээ.....	37
Шалгуур 6. Сургалтын үйл ажиллагаа	9
6.1. Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл	9
6.2. Сургалт арга зүй.....	10
6.3. Суралцагчийн үнэлгээ	11
шалгуур 7. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ	38
7.1 Хөтөлбөрийн үр дүн	39
7.2. Хөтөлбөрийн үр нөлөө.....	40
7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх	Error! Bookmark not defined.
not defined.	
7.4. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал	Error! Bookmark not defined.
Шалгуур 8. Чанарын үнэлгээ, баталгаажилт.....	Error! Bookmark not defined.
8.1. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ	Error! Bookmark not defined.
ДҮГНЭЛТ.....	41
ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭЦСИЙН ДҮГНЭЛТ:	Error! Bookmark not defined.
V.Оролцогчдын нэрс	45
I. Оюутны нэрс	45
II. Төгсөгчдийн нэрс	47
III. Ажил олгогчидтой хийх уулзалт	47
IV. Багш нартай хийсэн уулзалт	47
VI. ХӨТӨЛБӨРИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БАГААС ИРСЭН САНАЛ.....	49
VII. МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭР.....	51
VIII. МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ КОМИССЫН ШИЙДВЭР.....	51

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

БСШУСЯ – Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

БМИҮЗ- Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл

ХНН УБТЗ – Хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр зам

ТЗДС – Төмөр замын дээд сургууль

Н – Хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замын дарга

НЗ1 – Хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замын нэгдүгээр орлогч дарга

НГ – Хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замын ерөнхий инженер

НК – Хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замын хүний нөөцийн алба

Т – Хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замын Зүтгүүрийн аж ахуйн алба

Л – Хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замын зорчигч тээврийн алба

РЖД – Российские железные дороги

ОМГУПС – Омский государственный университет путей сообщения

МС – Төмөр замын дээд сургуулийн мэргэжлийн салбар

БНУТ – Байгаль нийгмийн ухааны тэнхим

ХСТ – Хэл соёлын тэнхим

НТОНХМ – Нийгмийн түншлэл олон нийт хариуцсан мэргэжилтэн

ӨҮБ – Өөрийн үнэлгээний баг

ӨҮТ – Өөрийн үнэлгээний тайлан

I. МАГАДЛАН ШИНЖЛЭХ ҮЙЛ ЯВЦ, ТӨЛӨВЛӨЛТ

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Төмөр замын дээд сургууль Mongolian Railway Institute		
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Зүтгүүрийн аж ахуй Railway locomotive engineering		
Индекс	D104101		
Шинжээчид	Ахлагчийн нэр, ажил, албан тушаал: 1. Д.Баатархүү, ХААИС – ийн Инженер технологийн сургуулийн сургалт эрхэлсэн орлогч захирал Гишүүдийн нэр, ажил, албан тушаал: 2. С.Ариунбаяр, ШУТИС -ийн Механик тээврийн сургуулийн Тээврийн салбар менежментийн хөтөлбөр хариуцсан дэд профессор 3. Т.Мөнхцэцэг, Зам тээвэр, хөгжлийн яам Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн		
БМИҮЗ-ийн зохицуулагч	Н.Түмэнжаргал		
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/	
	2018.05.02	Шинжээчийн багийн бүрэлдэхүүнийг танилцуулах - сургуулийн захиргаа, өөрийн үнэлгээний баг, багш нарт /мэргэжилтэн/ Магадлан итгэмжлэлийн үйл явц, 2 өдрийн ажлын хуваарийг танилцуулах /Шинжээчийн багийн ахлагч/ Сургуулийн захирал, өөрийн үнэлгээний багийн зүгээс Хөтөлбөрийн таницуулга хийх Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцах Сургууль, номын сан болон лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцах Оюутнуудтай уулзах Багш нартай уулзах Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцах	
	2018.05.03	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах Ажил олгогчидтой хийх үүлзалт Төгсөгчидтэй хийх уулзалт Шинжээчид дүгнэлтээ хэлэлцэн, гаргана. Нэмэлт материал үзэх танилцах Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.	
	Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ -ийн Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн 7 шалгуур шаардлага	

II. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

Хөтөлбөрийн нэр: Зүтгүүрийн аж ахуй

Хөтөлбөрийн индекс: D104101

Сургалт явуулах хэлбэр: Өдөр

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгжийн хаяг:

Төмөр замын дээд сургууль, УБ хот, Баянгол дүүрэг 2–р хороо, Энхтайвны өргөн чөлөө–44, Шуудангийн хайрцаг: 210535

Хөтөлбөрийг шууд хариуцах захирал:

Сургалт, эрдэм шинжилгээ хариуцсан дэд захирал В.Сэлэнгэ, утас: 244262

Вагоны аж ахуй мэргэжлийн хөтөлбөрийн дэд професор:

С.Галбадрах, утас: 89070088

Сургалт явуулж ирсэн түүх, туршлага:

✓ МАХН-ын ТХ-ний Улс төрийн товчооны 1953 оны 07 дугаар сарын 14-ний өдрийн 49/129 тоот тогтоолоор УБТЗ-ын ХЭГ-ийн дэргэд “Төмөр замын техникум” байгуулагдаж шийдвэр гарч, 1953-1954 оны хичээлийн жилээс эхлэн төмөр замын ашиглалт болон вагон гэсэн 2 мэргэжлээр 60 сурагч, 6 багштайгаар анх сургалтын үйл ажиллагаа эхэлж байжээ.

- ✓ 1953 оноос зүтгүүрийн мэргэжлээр сургалт явуулж эхэлсэн.
- ✓ 1956-1957 оны хичээлийн жилээс эхлэн илчит тэрэгний машинч бэлтгэх байнгын курсын салбар нээгдсэн байна.
- ✓ 1962-1963 оны хичээлийн жилээс эхлэн УБТЗ-ын даргын шийдвэрээр ашиглалт, илчит тэрэгний механикч, төмөр замын санхүү, эдийн засгийн оройн ангиуд хичээллэж эхэлжээ.
- ✓ 1991 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 176/А-57 тоот БНМАУ-ын Боловсролын яам, УБТЗ-ыг ХЭГ-ийн хамтарсан тушаалаар тус сургууль Төмөр замын коллеж болсон байна. Анхны бакалаврын зэргээр сургалт явуулж эхэлсэн.
- ✓ 1996 оноос Зүтгүүрийн аж ахуй мэргэжлийн бакалаврын сургалтыг 5 жилээр зохион байгуулсан.
- ✓ 2010 оноос Зүтгүүрийн аж ахуй мэргэжлийн бакалаврын сургалтыг 4 жилээр зохион байгуулсан.
- ✓ 2013 Зүтгүүрийн аж ахуй мэргэжлийн техникчийн сургалтыг эчнээгээр зохион байгуулсан.
- ✓ 2013 оноос Зүтгүүрийн аж ахуй мэргэжлийн магистрын сургалтыг эхлүүлж 2017 онд оюутан төгссөн.
- ✓ 2018 оноос Зүтгүүрийн аж ахуй мэргэжлийн эчнээ бакалаврын сургалтыг эхлүүлсэн.

Сургалтын хөтөлбөр шинэчлэлтийн ажлыг хийхдээ Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/78 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай”, 2014 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/174 дүгээр тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”, 2014 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/299 тоот “Ажил эрчимжүүлэх тухай”, 2014 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/370 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”-уудыг тус

тус баримтлан боловсруулав. 1993, 1996, 2000, 2013, 2014, 2017 онуудад бакалаврын болон техникчийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг өөрчлөн, шинэчлэн сайжруулсан.

Бакалаврийн сургалтаар-зүтгүүрийн аж ахуй 4 жил, Магистрын сургалтаар-1.5-2.0 жил тус тус шаталсан сургалтын системийг нэвтрүүлж, энэ хөтөлбөрөөр 146 оюутан суралцаж байна (Хүснэгт 1.1).

Хүснэгт 1.1

Зүтгүүрийн аж ахуйн мэргэжлийн хөтөлбөр

Д/д	Мэргэшүүлэх чиглэл	Өдрийн анги				Эчнээ	Бүгд
		I	II	III	IV		
Бакалаврын сургалтын хөтөлбөрөөр							
1	Зүтгүүрийн аж ахуй	29	35	26	26	30	146

Оюутны үйлдвэрлэлийн дадлагыг УБТЗ-ын Замын даргын тушаалаар жил бүр тогтмол хугацаанд Зүтгүүрийн аж ахуйн албаны салбар нэгжүүд дээр ирээдүйн ажлын байран дээр нь зохион байгуулдаг. Үүнээс гадна хоёрдугаар курсээс эхлээд өөрийн саналаар зүтгүүрийн депонуудад “Оюутан отряд”-д цалинтай (нэг дүгээр зэрэгтэй засварчны цалингийн 80 хувьтай тэнцэх) ажиллах боломжийг нээж өгсөн нь өөрийгөө хөгжүүлэх маш том боломжийг бүрдүүлсэн. Дадлагаар ажилласан хугацаа, эзэмшсэн чадвар зэргийг харгалзан сургууль төгсөхөөс нь өмнө зүтгүүрийн засварчны мэргэшлийн зэрэг, туслах машинчийн үнэмлэхтэй төгсгөхөөр ажил олгогчтой хамтарсан төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Зүтгүүрийн аж ахуй хөтөлбөрөөр бакалаврын ангид суралцах оюутнууд нийт 129 кредит цагийн агуулгыг бүрэн судалж бакалаврын зэрэг эзэмшинэ.

ТЗДС-ийн сургалтын полигоныг 2017-2018 оны хичээлийн жилд бүтээн байгуулсан ба мэргэжлийн хичээлийн семинар, лаборатори, үйлдвэрлэлийн болон төгсөлтийн өмнөх дадлагын ажлыг тус тус хийж гүйцэтгэдэг. Мөн ачаа, зорчигчийн вагоны бүх төрлийн эд ангийн хэмжилт, туршилтыг хийдэг ба автотоормос, цахилгаан хангамж, халаалтын систем нь бүрэн ажиллагаатай гэдгээрээ онцлогтой.



Зураг 2.1 Сургалтын полигон дахь ТЭМ-2 илчит тэрэг

Ш. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

ШАЛГУУР 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтанд оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан.

Илрэл нотолгоо:

- Төрс засгийн бодлого, мөрийн хөтөлбөртэй уялдуулан хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг гаргасан байна.
- Омскийн зам харилцааны их сургуулийн хөтөлбөртэй харьцуулан ялгаатай, давуу, сул талыг гарган дүгнэлт өгсөн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого 2010 онд батлагдсан, Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төмөр замын сүлжээг өргөтгөх, хөгжүүлэх бодлого, арга хэмжээ, Монгол оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн шинэчлэл хөгжлийн хөтөлбөр 2030-ын зорилго, зорилтуудтай уялдуулан тайлбарлаж эрэлт хэрэгцээг гаргасан байна.
- Сургалтын хөтөлбөрийг ОХУ-ын Омскийн зам харилцааны их сургуулийн хөтөлбөртэй сургалтын орчин, оюутны үйлчилгээ, сургалтын хөтөлбөр зэрэг 3 үндсэн бүлэгт хувааж 13 үзүүлэлтээр харьцуулан шинжилсэн байна.

Анхаарах асуудал:

- Мэргэжилтний эрэлт хэрэгцээ цаашдын өсөлтийг гаргахдаа сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийх.
- Хөтөлбөрийг ижил төстэй 2 доошгүй хөтөлбөртэй харьцуулан дүн шинжилгээ хийх.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагыг гаргахдаа төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого, засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгцээт мэргэжилтний тоон үзүүлэлтэд шинжилгээ хийж, цаашдын чиг хандлагыг тодорхой гаргах

1.2. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Сургуулийн эрхэм зорилго, зорилт, стратеги төлөвлөгөө, хөтөлбөрийн зорилго, зорилтыг тодорхойлсон баримт бичигтэй.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн зорилго, зорилт нь дээд сургуулийн эрхэм зорилго, зорилтуудыг дэмжсэн, харилцан уялдаатай байна.
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалтыг хөтөлбөрийн зорилго, зорилтын уялдаа холбоог гаргасан байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн үзэл баримтлал, мэргэжилтний загварыг тодорхой гаргах.
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн талаар баримт материал, тайлан харагдахгүй байна.

Зөвлөмж:

- Төгсөгчийн загварыг гаргахдаа нийгэм, эдийн засаг, улс төр, техник технологийн хөгжилтэй уялдуулан шаардагдах ур чадвартай уялдуулж сайжруулах.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байна.
- Хөтөлбөрийг хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэлүүдийг нотлох баримтаар бэлдсэн байв.
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөг гаргасан, батлагдсан хичээлийн стандарт хөтөлбөртэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тус хөтөлбөр нь БШУ-ны сайдын А/78 мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай, А/174 тоот тушаалын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу боловсруулагдсан байна.

Анхаарах асуудал:

- Батлагдсан хичээлийн стандарт хөтөлбөрт зарим хичээлээр олгох ур чадварууд хэтэрхий олон байгааг анхаарах.
- Идэвхтэй сургалтын арга зүйг хэрэглэж хэвших
- Оюутан, төгсөгч, ажил олгогч зэрэг хөтөлбөрт оролцогч талуудын санал зөвлөмжийг тусган хөтөлбөрийг тогтмол сайжруулдаг талаар тайланд тодорхой ойлгомжтой оруулаагүй

Зөвлөмж:

- Суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлэх аргыг оновчтой болгох
- Сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 2. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1. Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн индекс болон суралцахуйн үр дүнгийн матрицыг тодорхойлсон боловч хөтөлбөрийн багаар ажиллаагүй учир хөтөлбөрийн үндсэн багш нар үр дүнгийн матрицаа тодорхой сайн мэдэхгүй байснаас гадна багшийн бэлдсэн хичээлийн стандарт төлөвлөгөөнд тусгагдсан оюутанд олгох мэдлэг, ур чадвар, хандлагын үзүүлэлт энэхүү матрицид тусгагдсан тухайн хичээлээр оюутанд олгох мэдлэг, ур чадвар, хандлагын үзүүлэлтээс зөрөх тохиолдол гарч байсан.
- Удирдлагын мэдээллийн системийн хувьд UNIMIS системийг ашиглаж эхэлсэн бөгөөд, одоо E-CLOUD UNIMIS системийг бүрэн нэвтрүүлээд багш, оюутан, удирдлагын ажилтнууд сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг харилцан солилцдог болсон байна.
- 1993, 1996, 2000, 2013, 2015, 2017 онуудад бакалаврын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг өөрчлөн шинэчлэх сайжруулсан. Одоогоор хөтөлбөрийн хүрээнд нийт 129 кр-ийн хичээл үздэг бөгөөд үүнээс 28,7% Ерөнхий суурь ба математик, суурь шинжлэх ухааны хичээлүүд /30%-аас хэтрэхгүй байх/, 24% Мэргэжлийн суурь хичээлүүд /25%-аас хэтрэхгүй байх/, 38,8% Мэргэжлийн хичээлүүд эзэлдгээс гадна 4,6% Дадлага, 3,9% нь Төгсөлтийн шалгалт/ дипломын ажил /Мэргэжлийн нийт багц 45%-аас багагүй байх/ эзэлдэг байна. Энэ нь МУ-ын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оы 04 сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаалын шаардлагыг хангаж байна.
- Дадлагын ажлыг Мэргэжилтэй танилцах дадлага /1кр-70 цаг/, Үйлдвэрлэлийн дадлага /4кр-320 цаг/, Төгсөлтийн өмнөх дадлага /1кр-70 цаг/ гэсэн 3 түвшинд хийдэг. УБТЗ ХНН-ийн дүрмийн 22 дугаар зүйлийн “а” заалт, УБТЗ-ын даргын 2017 оны 11-р сарын 16-ны А-449 тоот тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан “Үйлдвэрлэлийн дадлагын дүрэм”-ийг даган үйлдвэрлэлийн дадлагаа УБТЗ-ын Зүтгүүрийн аж ахуйд 2 сарын хугацаанд хийдэг. Дадлага хийх хугацаан дах ХАБ-ын зааварчилгаа болон дадлагын удирдамж оюутнуудад тараагддаг.
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан графикыг тодорхойлсон байна.
- Зүтгүүрийн аж ахуй хөтөлбөрөөр оюутан 1А улиралд 15кр, 1В улиралд 19кр, 2А улиралд 18кр, 2В улиралд 16кр, 3А улиралд 16кр, 3В улиралд 17кр, 4А улиралд 15кр, 4В улиралд 12кр тус тус сонгон үзэхээр ачаалал хуваарилагдсан.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн кредит системд бүрэн шилжиж, дээд боловсролын болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын удирдлага, мэдээлэл, хяналтын систем UNIMIS програмыг сургуулийн бүхий л шатны үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.

- УБТЗ-ын Зүтгүүрийн аж ахуйг 2019 онд сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсанаар Үйлдвэрлэлийн дадлагыг цалинтай хийлгэдэг болсон бөгөөд УБТЗ-ын даргын шийдвэрээр төгсөгчдийг зүтгүүрийн засварчны III зэрэг, зүтгүүрийн туслах машинчийн үнэмлэхтэй төгсгөх гэсэн албан үүргийн дагуу оюутнууд 3-р курсын үйлдвэрлэлийн дадлагын хугацааны төгсгөлд дадлага хийсэн оюутан зэргийн шалгалт өгч шаардлага хангасан тохиолдолд үнэмлэх авах төлөвлөгөөг энэ хичээлийн жилээс боловсруулан ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн багаараа хамтран сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн буюу хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалтыг бүрэн тодорхойлж, хичээл болон суралцахуйн үр дүнгийн матрицыг эцэслэн боловсруулж, багш нарын хичээлийн төлөвлөгөөнд оруулуулах.
- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт хоорондын хамаарлыг харуулсан сургалтын төлөвлөгөөний матрицад үзүүлснээр нэг хичээл хэт олон мэдлэг, ур чадварыг олгож байна, түүнийг дахин хянаж, засварлах. CDIO аргын хүрээнд хичээл тус бүр дунджаар 4-8 хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй холбоотой байхаар төлөвлөвөл тохиромжтой гэж үздэг.
- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт хоорондын хамаарлыг харуулсан сургалтын төлөвлөгөөний матрицад үзүүлсэн тухайн хичээлийн сурагчид олгох мэдлэг чадвар нь багш нарын бэлдсэн хичээлийн төлөвлөгөөнд тусгагдсанаас ялгаатай байна.
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа хийдэг болох.

Зөвлөмж:

- CDIO арга зүйг дахин нягтлан ойлгох
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнг хөтөлбөрийн багаараа дахин нягталж боловсруулаад аль хичээлээр ямар мэдлэг чадвар олгохыг дахин хэлэлцэж тогтох
- Цөм хичээлүүдийг тодорхойлж, хөтөлбөрийн модонд оруулах
- 1В болон 2А улирлуудад 18-19кр-ийн 8-9 хичээл үзэхээр сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан байгааг анхаарч, ачааллыг жигд хуваарилах.

2.2. Сургалт арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмжийг боловсруулан тайланд тусгасан.
- Мэргэжлийн хичээлүүдэд ашиглаж байгаа идэвхитэй сургалтын арга зүйг хүснэгтээр тодорхойлсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын арга зүй нь багшийн сургах арга, оюутны сурах үйл ажиллагааны бүрдэл бөгөөд оюутан төвтэй байж, тэдний оролцоог дэмждэг байна. Үр дүнд суурилсан боловсролын үзэл баримтлалтыг ашиглаж эхэлснээр сургалтын үр дүнг суралцагчийн эзэмшсэн мэдлэг, ур чадвараар үнэлэх, зөвхөн онолын мэдлэг олгох бус практик ур чадварыг онолтой хослуулах аргыг эрчимтэй нэвтрүүлж байна.

- E-CLOUD UNIMIS системийн тусламжтай тухайн хичээлийн онцлог, зорилго, зорилт, үнэлэх журам зэрэг нь оюутанд тодорхой байхаас гадна лекц, семинар, лабораторийн хичээлүүдээр үзэж, унших материалуудад оюутнуудад хүргэгдэж эхлээд байна.
- Өөрсдийн бүтээсэн теранижэрийг сургалтанд ашиглан симуляци хийхээс гадна зориулагдсан орчинд суурилсан сургалтыг явуулдаг.
- Бүрэн тоноглогдсон лабораториудад сургалт явагдаж байгаа нь одоо ашиглагдаж байгаа зориулагдсан орчинд суурилсан сургалт, туршилтад суурилсан сургалт, тоглоом болон симуляцийн аргуудыг илүү үр дүнтэй болгож байна.

Анхаарах асуудал:

- Хэдийгээр мэргэжлийн хичээлүүдэд ашиглагдаж байгаа идэвхитэй сургалтын арга зүйг тайланд нэгтгэсэн байгаа боловч эдгээр арга зүй нь багш нарын хичээлийн стандарт төлөвлөгөөнд тусгагдсан идэвхитэй сургалтын арга зүйтэй зөрж байгаа тул тайлан тусгасан нэгтгэсэн хүснэгтийг дахин боловсруулж хянах.
- Сургалтанд ашиглагддаг ном гарын авлага ховор байна.

Зөвлөмж:

- Мэргэжлийн хичээлүүдэд ашиглагдах ном гарын авлага, хичээлийн удирдамжийг багш нараар боловсруулуулж идэвхитэй сургалтын аргатай хослуулан ашиглах

2.3. Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Уламжлалт кредит системийн үнэлгээгээр багшийн 70, улирлын шалгалтын 30 оноогоор үнэлэгддэг. Багшийн 70 оноо нь ирц идэвхийн 15, сорилт I, II-ийн 30, явцын буюу бие даалтын 25 оноогоор задардаг.
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ тайланд тусгагдаагүй. Хичээлийн стандарт төлөвлөгөөнд ямар шаардлагуудыг хангаж байж оноог бүтнээр нь авах нь тодорхой тусгагдаагүй байна.
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам тайланд тусгагдсан ба түүнийг нотлох албан ёсны бичиг баримт байхгүй. Ажил олгогчид захиалгат сэдэв өгч төгсөлтийн ажил удирдаж болдог.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Оюутныг тасралтгүй хөгжүүлэх Блумын таксономи болон Рубрик аргын хэрэглээг хэвшүүлэх. Зөвхөн хичээлийн агуулгыг мэдэж байгаа эсэхийг үнэлэхээс гадна хичээл бүрээр олгохоор тодорхойлсон мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлдэг болох.
- Суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, эрх тэгш зарчмыг хангасан байдалд оюутны өгсөн үнэлгээг нэмэгдүүлэх боломжийг анхаарах.

Зөвлөмж:

- E-Cloud UNIMIS системээ ашиглан суралцагчдын үнэлгээний дүн шинжилгээг хичээл нэг бүрээр тогтмол хийдэг болох, суралцагчдын үнэлгээнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодруулах, суралцагчийн дүнг нэмэгдүүлэх боломжуудыг эрэлхийлэх
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл боловсруулалт, нэгдсэн дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюуны тоо, амжилт, чанар гэх мэт/ тогтмол хийж занших

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.


3.1. Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

Зүтгүүрийн аж ахуйн хичээлийн анги танхим нь эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны хэм хэмжээнд нийцсэн, хүчин чадал нь сургалтын үйл ажиллагаанд хангалттай хүрэлцээтэй, сурахболон сургах орчин нөхцөлийг бүрдүүлсэн Сургуулийн барилга байгууламж нь газар хөдлөлтийн 7-8 баллыг тэсвэрлэх чадвар, нэг оюутанд ноогдох ашигтай талбай нь 3.9м², нэг багшид ноогдох ашигтай талбай нь 5.3 м², дотуур байранд амьдрах нэг оюутанд ноогдох талбай 4.2м², ашиглалтын коэффициент нь 1.4, байгаа нь MNS5566:2005 стандарт, Барилгын эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа болон БНБД 31-03-03 дүрмийн шаардлагыг хангасан байна.

Суудлын тоог оюутны тоотой харьцуулсан байдал



3.2 дугаар зураг. Зүтгүүрийн аж ахуйн суудлын тоо болон оюутны тоон харьцуулалт.

3.3 дугаар хүснэгт

Зүтгүүрийн аж ахуйн лабораторийн өрөө, анги, танхимуудын үзүүлэлт

Өрөө тасалгааны дугаар	Баригдсан он	Их засвар хийсэн огноо	Суудлын тоо	Ашиглалтын зориулалт
303	1995	2004	32	Илчит тэрэгний цахилгаан тоноглол
305	1995	2004	32	Зүтгүүрийн бүтцийн лаборатори
04	2004	2016	32	Галт тэрэгний автотоормосын ажиллагаа ба туршилтын тренажёр
03	1995	2012	28	Зүтгүүрийн бүтэц, засварын лаборатори

Сургалтын орчин, лабораторийн хүрэлцээ, хангамж, нөхцөл зэргээр оюутнуудаас улирал бүр сэтгэл ханамжийн судалгаа авч ажилладаг.

ОХУ-ын Москвагийн Зам Харилцааны Их Сургууль, БНХАУ-ын Бээжингийн Зам Харилцааны Их Сургууль, БНСУ-ын Тээврийн үндэсний их сургуулиудтай хос диплом олгогдох хамтарсан хөтөлбөрүүд хэрэгжүүлэхээр ажиллаж эхлэж байгаа нь Олон улсын сургалтын хөтөлбөрт шилжих, тэдгээрт шаардлагад дүйцэхүйц сургалтыг явуулж, сургуулийн сургалтын, хөтөлбөрийн түвшинг дээшлүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Зүтгүүрийн аж ахуйн ангийн оюутнуудыг төмөр замын тээврийн салбарын үйл ажиллагааны хэрэгцээ, шаардлагад нийцэх өрсөлдөх, хөрвөх чадавхи бүхий мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэх, мөн бүх төрлийн зүтгүүрийн гэмтэл, согогийг илрүүлэн оношлох, засварлах, техникийн үйлчилгээ хийх түүний найдвартай ажиллагааг ханган ажиллах, эрдэм шинжилгээ судалгааны ажил гүйцэтгэх, багаар ажиллах чадвартай, харилцааны соёлтой зөв төлөвшилтэй мэргэжилтэнг бэлтгэхэд чиглэгдсэн хөтөлбөрийг нэвтрүүлж байгаа нь онцлогтой байна.

Анхаарах:

- Зүтгүүрийн аж ахуйн хөтөлбөрийг амжилтаа хэрэгжүүлэхээс гадна төгсөгчдийн гадаад хэлний түвшин болон судлаач оюутануудыг бэлтгэх чиглэлээр онцгой анхаарч тэдний өрсөлдөх, хөрвөх чадварыг дээшлүүлэн хөгжүүлэх чиглэлээр хөтөлбөрт нэмэлт оруулан зохион байгуулалт хийж ажиллах нь шаардлагатай гэж үзэж байна.
- Шинэчилсэн хөтөлбөрийг боловсруулж, “Улаанбаатар төмөр зам”-ын Зүтгүүрийн албаны Ерөнхий инженер, сургалтын инженер болон бусад ИТА нараар хэлэлцүүлж, санал шүүмжлэл, зөвлөгөө авч, хөтөлбөрт тусган гэж тэмдэглэсэн байна. Иймд эдгээрийн санал шүүмжлэл, зөвлөгөөг онцгойлон анхаарч дадлагын чанарыг дээшлүүлэх, хугацааг сунгах, мэргэжил дээшлүүлэх орой, эчнээ ангийн сургалтын чанарыг сайжруулах шаардлагатай.

Зөвлөмж:

- Лаборатори, анги, танхимын техник хэрэгсэл, сургалтын тоног төхөөрөмж, ширээ, сандлыг шинэчлэн сайжруулах

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангагдсан байна.

Илрэл нотолгоо:

Зүтгүүрийн аж ахуйн мэргэшүүлэх хичээлүүдийг машинчийн кран №394 туршиж, хүлээж авах, туслах тоормосын кран №254 ажиллагааг шалгах, тоормосын даралтын реле №404 ажиллагааг шалгах, ачааны вагоны тоормосын ажиллагааг шалгах, турших зэрэг анги танхимд зааж байна.

Зүтгүүрийн тоормосын системийн эд ангиудыг задалж засварлах, угрсах ажиллагааг, сурч, судлан, дадлагажих ажлуудыг хийх боломжийг бүрдүүлсэн байна (Зураг 3.3).

Зүтгүүрийн автомат тоормосын лаборатори №03:



3.3 дугаар зураг. Хөдлөх бүрэлдэхүүний авто тоормосын лаборатори

Зүтгүүрийн цахилгаан тоноглолын лабораторыг 2М62М илчит тэрэгний цахилгаан тоноглолоор бүрэн тоноглож, 2М62М илчит тэргийг асаах үеийн цахилгаан схем болон цахилгаан тоноглолын ажиллагааг судлах, турших, байрнаас хөдөлгөх үеийн цахилгаан схем болон цахилгаан тоноглолын ажиллагааг судлах, турших, цахилгаан тоноглол, реле контакторуудын зохион байгуулалт, ажиллагааг судалж, турших, цахилгаан схем гарах гэмтэл, сааталыг судалж засварлах, үзлэг үйлчилгээ хийх технологийг судлуулж лабораторийн ажил хийх боломжийг бүрдүүлсэн байна (Зураг 3.4).

Зүтгүүрийн цахилгаан тоноглолын лаборатори №303



3.4 дүгээр зураг. Зүтгүүрийн цахилгаан тоноглолын тренажёр

Зүтгүүрийн засварын лабораторт зүтгүүрийн эд анги, тоног төхөөрөмжид гарах гэмтэл саатал тэдгээрийн засварын технологийг судлах, засварын лабораторт илчит тэрэгний эд ангиудад технологийн дагуу задарагаа угсаргаа хийх, илчит тэрэгний эд ангиудыг зай хэмжээг технологийн дагуу хэмжих, хэмжилтийн үр дүнгээр дүгнэлт гаргах, эд ангиудын гэмтэл, согог, саатлыг судлах, засварын технологи боловсруулах зэрэг ажилбаруудыг хийж дадлагажиж байна (Зураг 3.5).

Зүтгүүрийн засварын лаборатори №09:



3.5 дугаар зураг. Зүтгүүрийн засварын лаборатори.

Сургалтын ТЭМ-2 илчит тэрэг дээр зүтгүүрийн бүтэц, засвар, хөдлөх бүрэлдэхүүний авто тоормос, хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл ахуйн чиглэлээр лаборатори, дадлагын хичээлүүдийг ордог (Зураг 3.6).

Зүтгүүрийн аж ахуйн сургалтын полигон:



3.6 дугаар зураг. Сургалтын ТЭМ-2 илчит тэрэг

Илчит тэрэгний хүчний төхөөрөмжийн бүтцийг судлах, технологийн дагуу засвар үйлчилгээ хийх, 14Д40 болон ПДМ1 хөдөлгүүрийн блоконд гадна үзлэг хийх, 14Д40 болон ПДМ1 хөдөлгүүрийн тахир гол шатуны механизмд үзлэг хийх, тахир голын үндсэн болон шатуны хүзүүнд хэмжилт хийх, 14Д40 болон ПДМ1 хөдөлгүүрийн үзлэгийн цонхоор цилиндрийн втулканд үзлэг хийх, 14Д40 хөдөлгүүрийн цилиндрийн таг клапаны механизмд үзлэг, задаргаа хийх, цилиндрийн тагыг өргөх дадлагын ажлыг хийж, гүйцэтгэж байна (Зураг 3.7).



3.7 дугаар зураг. Илчит тэрэгний 14Д40 дизель генератор

Илчит тэрэгний 14Д40 дизель генератор дээр турбокомпрессорт үзлэг засвар, мөн түлшний системийн форсунк, өндөр даралтын болон усны, шалгах, засварлах, тосны зэрэг насосуудыг шалган засварлах дадлагын ажлыг хийж мэдлэг чадварыг эзэмшдэг байна.

Энэ лабораторит зүтгүүрийн аж ахуйн ангийн оюутнууд 2ТЭ116УМ илчит тэрэгний цахилгаан тоноглолын сургалтын тренажэрууд дээр ажиллах, мөн илчит тэрэгний цахилгаан схемийн дагуу хананд байгаа цахилгаан самбар дээр ажиллаж, LED гэрлээр схемийн дагуу асааж, ажиллагааг компьютерт суулгасан Circuit Wizard программ дээр simulation хэлбэрээр үзэж хянах ба илчит тэргийг удирдлагын самбараас асааж, жолоодож ажиллуулна. Танхимд байрласан ханын цахилгаан самбарын схем дээр удирдлагын пультнээс өгөгдсөн даалгаварын дагуу илчит тэргийг асаах, байрнаас

хөдлөх, ерөнхий генераторын сэрээлтийг хийх, компрессорын удирдлагын болон хөргөлтийн хэлхээний бүрдэлтийг LED гэрлээр асааж ажиллагааг зарчмын дагуу хийж байгааг хянах, туршилтын цахилгаан хэлхээ бүхий ханын самбар дээр схемийн алдааг хайх, компьютерээс өгөгдсөн даалгавруудыг хийх, гарсан алдааг хайх, холбогч утсуудыг ашиглаж буруу хэлхээнд холбох үед анхааруулах дохио дуугарч байгааг шалгах, мөн удирдлагын самбар дээр дизель генераторын хүчдэл, гүйдэл, тосны даралт заах манометер, ус болон тосны дулаан заах термометерүүд ажиллагаа, ханын самбарт суурилсан цахилгаан схемийн релейнүүдийн Bluetooth удирдлагаар асаах залгах, салган ажлуулах, салсан релений алдааг олж холбох, цахилгаан схем дээр нэг буюу хэд хэдэн алдааг олох, зэрэгцэн байрласан шонгууд дээр холболт хийж алдааг хайх бөгөөд алгасуулан холбох, цахилгаан схемийн Circuit wizard программ хангамжийг бүрэн ажиллуулж, цахилгаан схем зурах, ажиллуулах, туршилт явуулах, Circuit wizard программ нь цахилгаан ханын самбартай Arduino микроконтроллероор холбогдсноор үндсэн хэлхээнүүдийн бүрдэлтийг симуляци хэлбэрээр дэлгэц дээр харуулж ажиллуулж байна (Зураг 3.8).

Зүтгүүрийн цахилгаан тоноглол ба галт тэрэгний жолоодлогын лаборатори №303



3.8 дугаар зураг. Зүтгүүрийн цахилгаан тоноглолын тренажёр

Зүтгүүрийн аж ахуйн танхим, лаборатори, палигонд байрлуулсан стенд, сэлбэг, тоног төхөөрөмж, илчит тэрэг, хэмжих /микромметр, нутромерь, шаблом/ болон тохируулах хэрэгсэл, цахилгаан тоноглолын тренажёр зэрэг нэр бүхий 36 техник хэрэгслийг ашиглан тэргэнцэрийн арлын үзлэг шалгалт, цахилгаан хөдөлгүүрийн, хөргөлтийн секц, нуман ба пүршин рессор, цилиндрийн втулка, поршен, клапаны механизм, зүтгүүрийг асаах, байрнаас хөдөлгөх, галт тэрэгний автотоормосын, агаарын хуваарилагч, даралтын реле, автодэглэм, цахилгаан дамжуулга, форсунк, машинчийн кран, дотоод шаталтын хөдөлгүүр, пүршний суулт, цахилгаан машин, гүүшин, зэргийн шалгалт, туршилт, ажиллагаа, засвар болон хос дугуйболон энгийн магадлагаа болон хөндлөн гүйлтийн хэмжилт шалгалт, авто угсрааны, үзлэг хэмжилт, шалгах, батарей цэнэглэлт, тохиргоо, даралтын клапаны тохируулга, механик тоноглолуудын байрлал тогтоох мөн токарь болон гагнуурын ажиллагаа зэргийг хийж гүйцэтгэж байна.

Зүтгүүрийн аж ахуйн сургалтанд ашигладаг программ хангамжуудын судалгаа

д/д	Программ хангамжийн нэр	Он	Ашигладаг хичээл
1	Work beach	2008	Цахилгаан техник
2	Autocad	2015	CAD технологи
3	Solidworks	2013	CAD ба CAE технологи
4	Automation studio 5.0	2013	Инженерийн зургийн автомажуулалт
5	Proteus	2014	Микроконтроллерийн программчлал
6	Automation studio 5.0	2013	Хий шингэний хөтлүүр
7	3d Lab	2015	CAD технологи
8	Dev/ C++	2000	Алгоритм програмчилалын үндэс
9	Microc for pic	2014	CAD технологи
10	Atmel studio 5.0	2014	Микро контроллер процесс
11	Tech help	2010	Ассемплер
12	Packet tracer	2010	Мэдээллийн технологи ба сүлжээ
13	NI Circuit Design Suite 14.0	2014	Электроникийн үндэс, хэрэглээ
14	Proteus v8.6 SP1 Pro Incl	2016	Электроникийн үндэс, хэрэглээ
15	PiC C complier	2012	Электроникийн үндэс, хэрэглээ
16	Solidworks	2006	Автотоормос
17	Mathcad	2007	Цахилгаан машин, Дотоод шаталтын хөдөлгүүр
18	Mathcad 14	2014	Мэргэжлийн тооцооны автоматжуулалт
19	Excel	2014	Зүтгүүрийн татах онол
20	CAD, CAE		Инженерийн төсөл тооцоо
21	Mathcad 14, CAD, CAE		Зүтгүүрийн хийц, төсөл зохиомж

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Цэрэгжүүлсэн хамгаалалтын албанаас улирал бүр “Галын аюулаас урьдчилан сэргийлэх” үзлэг хийж, зөвлөгөө өгч, гарсан зөрчлийг арилгуулан ажилласан байна. MNS5566:2005 стандартын дагуу гал унтраах анхан шатны багаж хэрэгслээр бүрэн тоноглогдсон 84 ширхэг галын хор, хоолойг ашиглаж байна.
- Хичээлийн I, II байрны давхар бүрт ариун цэврийн өрөөтэй, төвлөрсөн дулаан, цэвэр бохир усны системд холбогдсон нь эрүүл ахуйн шаардлагыг хангаж байна.

- Сургуулийн дотоод хяналтын системийг сайжруулах зорилгоор хяналтын камер 16-г байршуулж, 2017 онд дахин сайжруулсан байна.
- Барилга байгууламж нь газар хөдлөлтийн 7-8 баллыг тэсвэрлэх чадвартай байна.
- Гэрэлтүүлэг, халаалт агаар сэлгэлт нь БНБД23-02-08 стандартад нийцсэн байна.
- Нэг оюутанд ноогдох нормт талбай 2.2м², нэг оюутанд ноогдох талбайн хэмжээ 3.9м² байгаа нь барилгын БНБД 31-03-03 стандартын шаардлагад нийцсэн байна.

Анхаарах:

- Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори нь хангалттай боловч багшийг сонгох боломж байхгүй, багш нарын зэрэг дэв чадамжийг дээшлүүлэх;
- Суралцагчийн сурлагын ахиц амжилтанд анализ дүгнэлт хийх, амжилтыг ахиулах судалгаа шинжилгээний ажил болон сургалтын үр дүн чанарыг дээшлүүлэх;
- Оюутны хандлага, төлөвшилт, чадамжийн үнэлгээний арга, хэлбэрийг сайжруулах.

Зөвлөмж:

- Мэргэжлийн хичээлийн анги, танхим, мэргэжлийн лабораториуд, сургалтанд ашиглагдаж байгаа компьютер, судалгаа сургалтын полигон зэрэг оюутан нар ажиллах хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, семинар болон лабораторийн хичээлийн сэдэв, агуулга бүрээр олж авах мэдлэг, дадал, чадварыг эзэмших арга аргачлал, заавар, гарын авлага сул байгаа тул сайжруулах.
- Зүтгүүрийн аж ахуй мэргэжлийн хөтөлбөрийн шаардлагыг бүрэн хангаж, үр дүнг сайжруулахын тулд физикийн лабораторийн тоног төхөөрөмж хэмжих хэрэгсэлийг сайжруулах, электроникийн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, цахилгаан техникийн, хийцийн материалыг боловсруулах лабораториудыг хөгжүүлэх, үл эвдэх сорилын болон метал, материал судлалын лабораториудыг иж бүрэн байгуулж, сургалтын орчин, материаллаг басыг бэхжүүлэн хөгжүүлэн, хэрэгцээг хангах.
- Зүтгүүрийн удирдлага тохируулгын автомат системийн лаборатори байгуулж ажиллуулах, мөн бусад их, дээд сургуулиудын лабораторийг гэрээгээр ашиглах хувилбарыг судалж хэрэгжүүлж оюутны мэдлэг чадварын хүрээг тэлэх.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Төмөр замын дээд сургуулийн номын сан нь 1955-1956 оны хичээлийн жилд анх байгуулагдсан. Одоо 40890 гаруй мянган ном, сурах бичиг, тогтмол хэвлэл, багш, оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн сан хөмрөгтэй. Үүнээс Зүтгүүрийн аж ахуйн мэргэжлийн ном 4300 гаруй ном, сурах бичиг байна. Нэг оюутанд ноогдох номын тоо 27.3 ширхэг, ойрын фонд 67м², үндсэн фонд 75м² уншлагын танхим 220.4м² хэмжээтэй, 120 суудал бүхий хичээлийн төв байранд байрлах уншлагын танхим болон оюутны дотуур байранд байрлах 47.5 м² талбай, 30 суудалтай уншлагын танхимуудаар үндсэн чиг үүргийн хүрээнд багш, ажилтан, суралцагчдын мэдээллийн хэрэгцээг хангах, танхимын сургалтаар олсон онолын мэдлэгийг бататгах зорилготойгоор, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төмөр замын дээд сургуулийн номын сан мэргэжлийн номын санчийн 3 орон тоотой ажилладаг.

“Журам шинэчлэх тухай” захирлын тушаалын дагуу номын сангийн үйлчилгээг, ном, сурах бичиг, гарын авлагыг гэрээр олгох, ажиллах цагийн хуваарь зэрэг үйл

ажиллагаа зохицуулж байна. Тус хичээлийн жилд 8'633'725 төгрөгийн 362 ширхэг ном, сурах бичгээр сан хөмрөгийн баяжилт хийсэн байна.

3.5 дугаар хүснэгт


Сургалтын компьютерийн судалгаа

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр, төрөл	Тоо ширхэг	Анги	Ашиглагдаж буй эсэх
1	Dell-Optiplex-3010, core-i3, 3.30 GHz,Ram 2GB,HDD 500GB	12	432	Ашиглагдаж байгаа
2	Dell, P-IV 3.0 GHz,Ram 512MB,HDD 80GB	1	432	Ашиглагдаж байгаа
3	Dell-Optiplex-330, Dual 1.8 GHz, Ram 1GB,HDD 160GB	13	203	Ашиглагдаж байгаа
5	Dell-Optiplex-380, P.Dual core 3.20GHz,Ram 2GB,HDD 500GB	7	209	Ашиглагдаж байгаа
6	Dell Pentium R, 2.7GHz, 2 GB Ram, HDD 500 GB	1	427	Ашиглагдаж байгаа
7	P-IV 3.0 GHz, Ram 512MB, HDD 80GB	1	123	Ашиглагдаж байгаа
8	Dell Optiplex -3040, Vore I5, CPU 3.2 GHz, RAM 4GB, HDD 500 GB	1	431	Ашиглагдаж байгаа
9	Dell-Optiplex-980, Core-i3, 3.20GHz,Ram 2Gb,HDD 290Gb	1	431	Ашиглагдаж байгаа
10	Dell, Core 2 Duo 2.9 GHz,Ram 1Gb,HDD 80 GB	1	310	Ашиглагдаж байгаа
11	Dell-Optiplex-380, Xeon 3.06 GHz,Ram 1 GB,HDD 160 GB	1	баас	Ашиглагдаж байгаа
12	Dell-Optiplex-330, Dual 1.8 GHz,Ram 1GB,HDD 160GB	1	02	Ашиглагдаж байгаа
13	Dell-Optiplex-3010, Core-i3, 3.36GHz, Ram 2GB, HDD 500GB	3	422	Ашиглагдаж байгаа
1	Сургалтын компьютер	1	03	Ашиглагдаж байгаа
2	Компьютер HP,i5,3.2GHz	1	303	Ашиглагдаж байгаа
3	Компьютер Dual core 2.6GHz	1	303	Ашиглагдаж байгаа
4	Компьютер Dual 1.8 GHz	4	303	Ашиглагдаж байгаа

Сургалтын хэрэглэгдэхүүн, програм хангамж, мэдээллийн технологийн сайжруулах чиглэлээр дараах ажлууд хийгдсэн байна.

- Сургууль байнгын үйл ажиллагаатай www.inststrans.mn гэсэн домайн нэр бүхий вэб сайттай. Энэхүү вэб сайт нь Datacom компаний сервер дээр байрлуулан тогтмол ажиллуулж байна.
- Сургалтын үйл ажиллагаанд 2012-2013 оны хичээлийн жилээс эхлэн StarSoft компанийн Uniface5.0 програмыг нэвтрүүлэн, удирдлага, мэдээлэл, хяналтын системд бүрэн ашигласан байна.
- ШУТИС-ын E-Cloud UNIMIS програмыг сургалтын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэн, ашиглаж байна.
- Номын сан, хичээлийн 2-р байрны №230, хичээлийн 1-р байрны №205, подваль, оюутны дотуур байрны 3, 4-р давхарт тус тусWifi утасгүй интернэт ашиглагдаж байна.

- MOVICOM –ийн WICOM төсөл хэрэгжин WifiAccess Point Ruckus-JF7372 утасгүй интернетийн төхөөрөмжийг дотуур байрны 1-4 давхар, хичээлийн 1-р байрны давхар бүрд 2ш, хичээлийн 2-р байрны 1-4 давхарт 1ш тус бүр суурилуулан, байнгын ажиллуулж байна
- 2017-2018 оны хаврын улирлаас эхлэн хичээл бүрийн улирлын шалгалтыг элсэлтийн ерөнхий шалгалт авдаг аргачлалаар авч тестийн машинаар дүнг гарган хэвлэн, мэдээлсэн байна.



3.10 дугаар зураг. Сан хөмрөгийн баяжилт /сүүлийн 5 жилээр/

Номын сангийн үйл ажиллагаа:

Төмөр замын дээд сургуулийн номын сан нь нийт 40980 номын фондтой, 140 суудалтай, 3 номын санчтайгаар үйл ажиллагаагаа явуулж, өдөрт дунджаар 150 багш, бакалавр оюутан, магистр, ажилтнуудад уншлагын танхимаар үйлчилж, гэрээр ном, сурах бичиг, гарын авлагыг олгож ажилласан байна. Номын фондын 60,1 хувь нь мэргэжлийн ном, сурах бичгээс бүрдэх ба хэвлэл захиалгаар “Ган зам, Өнөөдөр, Өдрийн, Зууны мэдээ зэрэг нийт 4 төрлийн сонин, мөн Төрийн мэдээлэл сэтгүүл, Инновации транспорта сэтгүүл, Железные дороги мира сэтгүүл, Контроль диагностика сэтгүүл, Локомотив сэтгүүл, Безопасность и охрана труда на железно-дорожном транспорте сэтгүүл, Путь путевое хозяйство сэтгүүл зэрэг нийт 6 төрлийн сэтгүүл захиалан багш, оюутнууддаа үйлчилсэн байна. Зүтгүүрийн аж ахуй чиглэлээр 3433 номтой байна.

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагаа, мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэрэгцээт ном сурах бичиг, гарын авлага, арга зүйн материалаар системтэй хангах, мэдээллийн эх үүсвэрийг бий болгох, шинээр гарсан мэргэжлийн номыг худалдан авч баяжилт хийж, E-Library номын сангийн цогц програмыг нэвтрүүлж өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглан сургуулийн багш, оюутан сурагчид ном, сурах бичиг, мэдээллээ авах боломжийг бүрдүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

3.6 дугаар хүснэгт

Нэмэлт ном, сурах бичгийн судалгаа

Түвшин	Төрөл	Тоо ширхэг	Хэл				Цахим
			монгол	орос	англи	япон	
Ерөнхий суурь хичээл	Хэвлэмэл ба цахим	34	17	5	10	-	2
Мэргэжлийн суурь хичээл		1129	548	566	2	-	18
Мэргэжлийн хичээл		160	118	31	3	-	8
Нийт /2651/		1323	683	602	15	-	28

Анхаарах:

- Номын тоо ширхэгийг судлан үзэхэд ном сурах бичгийн хангамжийг сайжруулж, нэн шаардлагатай хэрэгцээт ном, сурах бичгийн хөрөнгө, зардал шаардагдах төсвийг жил бүр гаргаж, төсөллөгдсөн өртгөөр баяжилтыг хийх;
- "Электрон номын сан" байгуулж, тогтмол хүртээмжтэй ажлуулах;
- Мэргэшүүлэх хичээлийн болон техникийн ухааны номууд, эрдэмтэд, судлаач нарын бүтээлүүдийг авч номын сангийн баяжилтыг хийх;
- Судалгаанаас үзэхэд номын санд сууж байгаа оюутнуудын тоо сул байгаа тул тэднийг ном сурах бичиг, сэтгүүл, аргачлал, гарын авлага, төсөл, судалгаа, диплом, диссертаци уншиж судлах ажлыг эрчимжүүлэх;
- Сургалтанд лицензтэй програм хангамжийг нэвтрүүлэх, зарим шаардлага бүхий компьютерийн техник үзүүлэлтийг өсгөж /Жишээ нь:RAM 16 GB-с дээш, Graphic card г.м/, 10-с дээш компьютертэй анги, лабораторуудыг агааржуулалтын системээр хангах;
- Сургалтанд нэн шаардлагатай стэндүүдийг нэмэгдүүлж, аргачлалыг боловсруулах, цахим хичээлийн файлыг бүрдүүлж оюутанд хаанаас ч, хэзээ ч суралцах боломжийг олгох.

Зөвлөмж:

- Номын сангийн шаардлагатай, нарийн мэргэжлийн болон шинжлэх ухааны бүтээлийн ном, сурах бичгийн тоо, төрлийг нэмэгдүүлэн, хангамжийг сайжруулж, баяжилтыг хийж, тэдгээрийг судлуулах ажлыг эрчимжүүлэх, багш нарыг ном, сурах бичиг, семинар, лабораторийн хичээлийн гарын авлага, шинжлэх ухааны бүтээлийг боловсруулж гаргахад дэмжлэг үзүүлэх;
- Номын санд Инноваци шингэсэн бүтээлүүд, төгсөгчдын диплом, диссертаци бараг байхгүй байгаа тул баяжуулж, оюутнуудад судлууулж, судалгааны ажлыг гүнзгийрүүлэх;
- Сургалтын полигонд хос дугуйн "мини" паркийг бүрэн байгуулж, аргачлал зааврыг боловсруулж энэ чиглэлийн мэдлэг, чадварыг эзэмшүүлэх;
- Жил бүр шинэ номоор фондын баяжилт хийх төсөвийг батлан хэрэгжүүлэх;

- Сургуулийн электрон каталогийн <http://opac.must-library.edu.mn> вэб-ийг ашиглалтад оруулж, номын эргэлтийг сайжруулж, хянах ажиллагааг автоматжуулж, эрэлттэй, олдоч багатай номыг цахим эх хөрвүүлэх ажлууд хийх;
- Зүтгүүрийн аж ахуйн албаны ажлын байранд тавигдах шаардлагын дагуу оюутны эзэмшвэл зохих чадваруудыг олгоход шаардлагатай лаборатори сургалтын тоног төхөөрөмжүүдийг шийдвэрлүүлэх.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн тэнхимийн шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш, суралцагчдын оролцоог хангасан байна
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудтай байна.
- Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэх ажлын үнэлгээ, гүйцэтгэлийн болон үр дүнгийн урамшууллын хэрэгжилттэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ТЗДС нь ХНН УБТЗ-ын харъяа аж ахуйн нэгж тул аливаа шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг шууд Зүтгүүрийн аж ахуйн албанд танилцуулж хамтран ажиллах төлөвлөгөөтэй ажиллаж сургалтын хөтөлбөрийг сайжруулахад ажил олгогчийн оролцоог хангадаг.
- Төгсөх болон болон суралцаж байгаа оюутнуудын хөтөлбөр дэх оролцоог сэтгэл ханамжийн судалгаагаар хангадаг байна.
- Сургалтын үйл ажиллагаандаа E-Cloud Unimis системийг нэвтрүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Оюутнуудын өгсөн сэтгэл ханамжийн судалгааны дүнг үндэслэн үйл ажиллагаагаа сайжруулсан зүйл харагдахгүй байна.
- Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан харагдахгүй байна.
- Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ байхгүй байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрт оролцогч болон сонирхогч талуудаас гарсан санал асуулгын дүнгийн дагуу хийсэн ажлыг тодорхой тусгаж, эргэж тайлагнадаг байх

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Мэргэжлийн чиглэлийн гэрээ, хэлцэл хийхэд оролцсон материал, гэрээт ажлын тайлан
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Евро-Азийн тээврийн сургуулиудын консерциумын албан ёсны гишүүн 2006 оноос хойш зохион байгуулсан синфозиумд тасралтгүй оролцож ирсэн байна. Тус хуралд багш нар 2 удаа илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна.
- ОХУ-ын гурван их сургууль, нэг хүрээлэнтэй, БНХАУ-ын хоёр их сургууль, нэг коллежтой, БНСУ-ын хоёр их сургууль, нэг дээд сургуультай хамтын ажиллагаатай.
- ОХУ-ын Эрхүү хотод 2 багш, БНХАУ-ын Бугат хотын төмөр замын коллежд 1 багш мэргэжил дээшлүүлэх, туршлага солилцох ажлуудыг хийсэн байна.
- БСШУСЯ, ХНХЯ, ЗТХЯ-ны харъяа бодлого хэрэгжилтийг зохицуулах газар, Монголын төмөр зам ТӨХК, Болд төмөр Ерөө гол ХХК гэх мэт компани, холбоо, төрийн бус байгууллага зэрэг 10 газартай хамтын ажиллагаатай байна.
- Сүүлийн гурван жилийн байдлаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай зүтгүүрийн машинч мэргэжлийн лавлах, мэргэшсэн инженерийн сургалт, галт тэрэгний жинг оновчтой тогтоох, зүтгүүрийн ашиглалтын бүтээмжийг дээшлүүлэх зэрэг судалгаа, төсөл хөтөлбөр, төмөр зам, галт тэрэгтэй холбоотой дүрэм, журам, хөдлөх бүрэлдэхүүний техникийн шаардлага, норм стандарт боловсруулах, төсөлд санал өгөх, сургалт зохион байгуулах зэрэг нийт 13 төрлийн үйл ажиллагаанд 4 багш оролцсон байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал, хөтөлбөр сайжруулалтад оролцсон байдал харагдахгүй байна.

Зөвлөмж:

- Хамтын ажиллагаатай орнуудад солилцоогоор явах багш, суралцагчдын тоог нэмэгдүүлэх

4.3. Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан

- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгааг гаргасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн нийт санхүүжилтийн 75% нь сургалтын төлбөр, 8% нь өөрийн бусад орлого, 6% нь мэргэжлийн боловсрол, сургалтын дэмжих сангийн орлого, 11% нь УБТЗ-ын татаасын эх үүсвэрээс бүрдэж байна.
- Хөтөлбөрийн санхүүжилтийн 1.7% нь багш, оюутны хөгжилд зарцуулагддаг байна.
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоог хийж нэг кредит цагийн үнэлгээг тогтоосон байна.
- Сургалтын иж бүрэн полигон байгуулахад засвар үйлчилгээний зардалд 300 сая төгрөгийн нэмэлт хөрөнгө оруулалт хийсэн байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр өөрөө өөрийгөө бүрэн санхүүжүүлэхэд анхаарч ажиллах

Зөвлөмж:

- Сургалтын төлбөрийн 1 кредит цагийн үнэлгээг дахин эргэн харж шинэчлэн тогтоох.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- УБТЗ-ын захиалгын дагуу оюутан элсүүлдэг
- Оюутан элсүүлэх дүрэм журамтай
- Төмөр зам дагуух шугам зам дагуух аймаг сумдад элсэлтийн сурталчилгааны ажлыг хийдэг.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутан элсүүлэх, хөтөлбөр хөгжүүлэх үйл ажиллагааг УБТЗ-ын захиргаа, мэргэжлийн албад, хүний нөөцийн албатай хамтран тэдний бодлого шийдвэртэй уялдуулан төлөвлөж хэрэгжүүлдэг байна.
- Эрхүүгийн ЗХИС-тай 2+3 хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангасан байна.

Анхаарах асуудал:

- Цаашид хөтөлбөр тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй болох
- Зөвхөн УБТЗ-ын хүний нөөцийн албанаас ирүүлсэн хяналтын тоогоор оюутан элсүүлэх биш эрэлт хэрэгцээнд тулгуурлан элсэгчийн тоог тодорхойлж элсүүлдэг болох

Зөвлөмж:

- Төгсөгчдийг мэдээллээр хангаж, мэргэжил суратлчлах, хөтөлбөрөөр оюутан элсүүлэхэд татан оролцуулах
- Бусад орны сургуулиудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Вебсайтын мэдээллийн иж бүрэн, тогтмол хангалттай ажиллагаатай.
- Оюутны гарын авлага, ган зам сонин.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тайлангийн жилүүдэд оюутны гарын авлага хэвлэж тараасан байна.
- Вебсайтын мэдээллийн иж бүрэн, тогтмол хангалттай ажиллагаатай.
- Ган зам сонингоор дамжуулан сургууль багш, оюутнуудын бүтээлийг дугаар болгонд 1 нүүр материал хэвлэдэг.
- Сургуулийн facebook хаягийг тогтмол ажиллуулдаг.

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 5. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Төмөр замын дээд сургууль нь Монгол Улсын “Дээд боловсролын тухай хууль”, “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль”, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын 2013 оны 03-р сарын 18-ны өдрийн А/79 тоот тушаалаар болон бусад холбогдох эрх зүйн актууд, “Төмөр замын дээд сургуульд оюутан элсүүлэх журам” зэргийг тус тус баримтлан, жил бүрийн хаврын элсэлтийн үйл ажиллагааг Улаанбаатар хот болон төмөр замын үндсэн 5 тулгуур өртөөнүүдэд зохион байгуулж, сургуулийн онлайн elselt.instrans.mn вэб хаягт бүртгэж, элсэлттэй холбоотой бүх мэдээллийг Ганзам сонин, сургуулийн цахим хуудас <http://elselt.instrans.mn/>, <http://www.instrans.mn/>-д байршуулан мэдээлэн элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:


ЗАА-н элсэлтийн судалгаанаас үзэхэд тус хөтөлбөрөөр элсэгч оюутны ЭЕШ-ын дундаж оноо жил ирэх дутам өсөх хандлагатай, энэ мэргэжлийг сонгон ирж байгаа хүүхдүүдийн суурь боловсролын төвшин өсч, элсэгчдийн чанар сайжирч байгааг үзүүлж байна.

5.1 дүгээр хүснэгт

Элсэлтийн босго оноо

Д/д	Хөтөлбөр индекс	Хөтөлбөрийн нэр /Мэргэжил/	Ерөнхий шалгалтын босго оноо	
			ЭЕШ-1 (62.5%)	ЭЕШ-1 (60%)
1	104101	Зүтгүүрийн аж ахуй	Математик 480	Физик 480

ЗАА-н хөтөлбөрөөр элсэгчдийн ЭЕШ-ын дундаж оноо



5.1 дүгээр зураг. Элсэгчдийн ЭЕШ-ын дундаж онооны үзүүлэлтийг үзүүлэв

Зүтгүүрийн аж ахуйн хөтөлбөрийн багш нар нь оюутнуудад, мөн хариуцсан ангидаа улирлаар болон жилээр соёл, хүмүүжлийн ажлын төлөвлөгөөг гаргаж, оюутнуудад хичээл сонголт, нийт суралцах хугацааныхаа ачааллыг тохируулах, суралцах үедээ хуримтлуулсан кредит, сурлагын үзүүлэлтээ тооцон шалгаж, түүний үр дүнгээс хамааран суралцах төлөвлөгөөгөөг шинэчлэн боловсруулах, сурлагын болон бусад асуудал үүссэн оюутны арга хэмжээг тухай бүрт авах, мөн цаг үеийн үйл ажиллагаанаас шалтгаалж, хурал зарлаж зөвлөх үйлчилгээг үзүүлэн хурлын протокол хөтлөн энэ чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажилласан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Зүтгүүрийн аж ахуйн хөтөлбөрт сургалтаар оюутнуудыг сонгож, элсүүлэхдээ, Төмөр замын гол зам дагуух үндсэн өртөөнүүд, түүнийг байрлах сум, аймгийн болон нийслэл, Улаанбаатар хотоос холбогдох хууль, журмын дагуу сонгон авсан байна. Мөн хүндэт төмөр замчин, үе дамжсан төмөр замчдын хүүхдүүд сонирхолоороо шалгалт өгч, элсэн орсон байна.

Анхаарах:

- Оюутны сурах, судалгаа шинжилгээний ажил хийх, дадлага чадварыг эзэмших, хөгжүүлэх ажлыг, төлөвлөлт, системтэйгээр хийж хэвших.
- Аж ахуй нэгж, үйлдвэрлэгчээс хүлээж буй эрэглтийг хангах, хөрвөх чадвар бүхий оюутаныг бэлтгэх. \инженер-электроник, инженер-үл эвдэх сорилчин, инженер-физикч, инженер-автоматжуулагч, инженер-програмист, инженер-гагнуурчин г.м\

Зөвлөмж:

- Сургуулийн WEB-ийн ажиллагааг сайжруулж, интернетийн орчинд дүн болон хичээлийн хуваариа харах, хичээл сонголт хийх, ТҮЦ машинаар тодорхойлолт болон дүнгийн хуудсыг дуртай үедээ оюутан өөрөө мэдээллийг хэвлэн авах боломжтой болгосон үүнийг улам хөгжүүлэн баяжуулах;
- Оюутны техник сэтгэлгээ, харилцааны ур чадвар, судалгаа шинжингээний ажил хийхийг хөгжүүлж, судлаач оюутнуудыг төрүүлэх;

- Оюутан интернет орчинд хүссэн цагтаа хичээлийн хуваарь харах, багшид үнэлгээ өгөх, хичээл сонголт хийх, дүн харах, даалгавар, зөвлөмж багшаа сонгох боломжийг бүрдүүлэх;
- Олон улсын төмөр замын болон техникийн их сургуулиудтай багш болон оюутнуудын туршлага судлах, сургалт арга зүй, судалгааны материалыг солилцох, баяжуулах ажлыг чанаржуулан, эрчимжүүлэх;
- Оюутны идэвхи, сургалтын чанар, судалгаа шинжилгээний ажлыг үр дүнгээр нь олон улсын сангаас олгогддог тэтгэлгүүд, дотоодын дүрэм, журмын дагуу олгогдох тэтгэлэг, урамшуулалт, санхүүжилт, урамшуулалтыг өрнүүлэн, хөгжүүлэн хэрэгжүүлэх.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Зөвлөх багш нар “Зүтгүүрийн аж ахуй” мэргэжлийн хөтөлбөрөөр суралцагчидад зөвлөгөө өгч ажиллахаас гадна тэднийг төлөвшүүлэх, даан өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр техник сонирхогчдын клуб, төсөл бичих уралдаант шалгаруулалт, сагсан бөмбөг, гар бөмбөг, үндэсний бөх, чөлөөт, жүдо, самбо бөх, бодибилдинг Фитнес зэрэг сайн дурын клубуудыг дэмжиж ажиллахаас гадна сургуулийн төлөвлөгөөт олон ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

Илрэл нотолгоо:

Сургуулийн захиргаа УБТЗ-ын Хүний нөөцийн алба, Зүтгүүрийн албатай хамтарч Дархан, Улаанбаатар, Сайншанд татах хэсгүүдийн хүний нөөцийн менежерүүдтэй төгсөх ангийн оюутнуудыг уулзуулж тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг жил бүр зохион байгуулан ажиллаж байна.

“Зүтгүүрийн аж ахуй” мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж буй нийт оюутнуудад туслах зөвлөх үйлчилгээ нь суралцагчдын баримтлах дүрэм, журмыг хэрэгжүүлэх, амжилттай сурах, мэдлэг дадлыг эзэмших, өөрийн хэрэгцээ, сонирхолын дагуу хөгжин төлөвших боломжийг бүрдүүлж, шилдэг оюутнууд урамшуулалт, тэтгэлэг авч нийгмийн идэвхээ хөгжүүлэн ажиллаж байна гэж үнэллээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Сургалтын кредит тогтолцоонд бүрэн шилжиж, оюутан бүр өөрийн сурах үйл ажиллагааг төлөвлөх, мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд заасан хичээлүүдийг зөв дэс дараатай сонгох, нийт суралцах хугацааныхаа ачааллыг тохируулах, суралцах үедээ хуримтлуулсан кредит, сурлагын үзүүлэлтээ тооцон шалгаж, түүний үр дүнгээс хамааран суралцах төлөвлөгөөгөө шинэчлэн боловсруулах шаардлагыг хангах зорилгоор багшийг оюутны *зөвлөх багшаар томилж*, оюутан суралцах хугацааныхаа турш зөвлөх багшаас зөвлөлгөө авч, асуудлыг хамтран шийдвэрлэх, сургалтын үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлаар зөвлөгөө авах, зөвлөх багш нь оюутныг төгсөх хүртэл нь зөвлөх үүрэгтэйгээр, тэднийг сурах, судалгаа шинжилгээ хийх, төлөвшүүлэх, хөгжүүлэхэд чиглэгдэн ажиллаж байна.

Анхаарах:

- Зүтгүүрийн аж ахуйн ангид суралцагчдын зөвлөх үйлчилгээ нь судалгааны арга зүйг түлхүү эзэмшүүлэхэд зөвлөх, мөн инженерийн мэргэжил, ёс зүй, хэмжил зүй, хөрвөн

ажиллах чадвар, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай явуулахыг анхаарах зүйтэй гэж үзэж байна.

Зөвлөмж:

- Зүтгүүрийн аж ахуйн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч, төгсөгчдийн эзэмших мэргэжлийн мэдлэг, ур чадварыг системтэйгээр, хөрвөх чадвартайгаар сайжруулах,
- Зүтгүүрийн аж ахуйн ангийн оюутнуудыг улсын болон олон улсын хэмжээнд зохион байгуулагддаг эрдэм шинжилгээний хурал, олимпиад, уралдаан тэмцээнд идэвхитэй, бүрэн чанартай сайн оролцож амжилтанд хүргэх чиглэлээр байнга бэлтгэх ажлыг тогтмол зохион байгуулах, зөвлөх, хамтран ажиллах.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

“Зүтгүүрийн аж ахуй” мэргэжлийн хөтөлбөрөөр суралцагчдын олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажиллах, амжилттай суралцах, өөрийн хэрэгцээ, сонирхлын дагуу хөгжин төлөвших боломжийг бүрдүүлэхээр оюутныг чиглүүлэх, зөвлөх, сургалтын алба, номын сан, цахим лавлагааны машин, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, дотуур байр, эрүүл мэндийн үйлчилгээ, оюутны тэтгэлэг, төмөр замаар жилд нэг удаа үнэгүй зорчих билет, СМАРТ карт, оюутан солилцоо, спорт, урлаг зал зэрэг үйлчилгээг үр дүнтэй үзүүлж байна.

Зүтгүүрийн аж ахуйн ангийн оюутнуудын нийгмийн идэвхи, оролцоог дээшлүүлэх, тэдний авьяас чадвар, хүсэл сонирхлыг урамшуулан дэмжих, хөгжүүлэх чиглэлээр сурлага, эрдэм шинжилгээ, урлаг, спортын онцгой амжилт гаргасан, мөн сургуулийн нэрийн өмнөөс олон улс, улс, бүс нутаг, бусад их дээд сургуулиудын дунд зохион байгуулагдах эрдэм шинжилгээний хурал, олимпиад, спорт, урлагийн уралдаан тэмцээн, наадмуудад амжилттай оролцсон, захирлын нэрэмжит болон оюутнуудын сайн дурын, мэргэжлийн клубүүдийн үйл ажиллагаанд оролцож, кредитийн болон мөнгөн урамшуулалтыг олгох үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

Төмөр замын тээврийн дээд сургуулийн нэрийн өмнөөс олон улс, улс, бүс нутаг, бусад их дээд сургуулиудын дунд зохион байгуулагдах эрдэм шинжилгээний хурал, олимпиад, спорт, урлагийн уралдаан тэмцээн, наадмуудад Зүтгүүрийн аж ахуйн оюутнууд амжилттай оролцож, байранд шалгарсан, захирлын нэрэмжит болон оюутнуудын сайн дурын, мэргэжлийн клубүүдийн үйл ажиллагаанд оролцож, кредитийн урамшуулалтыг оюутнууд авсан байна.

Зүтгүүрийн аж ахуйн ангид суралцдаг оюутан нар Улсын олимпиад, тэмцээнд жил бүр оролцсон байдал



5.2 дугаар зураг. Зүтгүүрийн аж ахуйн ангийн илтгэлд оролцогч нар

Илрэл нотолгоо:

“Зүтгүүрийн аж ахуй” мэргэжлийн хөтөлбөрийн дагуу суралцаж байгаа нийт оюутнуудын нийгмийн идэвхи, оролцоог дээшлүүлэх, тэдний авьяас чадвар, хүсэл сонирхлыг нь урамшуулан дэмжих, хөгжүүлэх зорилгоор шилдэг оюутнуудад урамшуулал олгох үйл ажиллагааг “Оюутныг урамшуулах тухай” журмын дагуу олгосон байна.

Сургуулийн хэмжээнд зохион байгуулагдсан арга хэмжээ, олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй тогтмол оролцсон, сайн дурын үйл ажиллагаа, оюутны клубууд болон эрдэм шинжилгээний хурал, олимпиад, спорт, урлагийн уралдаан тэмцээн, наадмуудад идэвхтэй оролцож байр эзэлсэн, 3,6 дээш голчтой сурлагын амжилт гаргасан оюутнуудад урамшуулалт олгосон судалгааг үзүүлэв.

5.2 дугаар хүснэгт

Зүтгүүрийн аж ахуй мэргэжлийн хөтөлбөрөөр суралцагч оюутнууд амжилттай суралцаж, олон нийтийн ажилд идэвхитэй оролцож урамшуулалт авсан судалгаа

Д/д	Оролцсон уралдаан тэмцээн	Урамшуулал авсан оюутны нэр	Оюутны код	Кр	Хэзээ
1	Метал судлалын улсын 6-р олимпиад	Ц. Отгонбилэг	DL15D28	1	2017-2018 2-р улирал
2	Материалын эсэргүүцэл, машин механизмын онол ТДС олимпиад	Б.Намсрай	DL15D28	1	2017-2018 2-р улирал
3	Материалын эсэргүүцэл, машин механизмын онол ТДС олимпиад	Э.Батбилэг	DL16D03	1	2017-2018 2-р улирал
4	CAD технологи машины эд анги	Б.Намсрай	DL15D28	1.5	2017-2018 2-р улирал
5	Эгэл жирийн загвараас шинжлэх ухаанд загвар зохион бүтээх уралдаан	А.Базаррагчаа	DL14D15	4	2017-2018 2-р улирал
6	Хайрын шүлгийн наадам	Б.Дугарсүрэн	DL14D47	1.5	2017-2018 2-р улирал
7	Хайрын шүлгийн наадам	Б.Лхагвабат	DL17D18	1	2017-2018 2-р улирал
8	Спорт наадам ТДС үндэсний бөх	Б.Анхбаяр	DL14D01	1	2017-2018 2-р улирал
9	Робокон-2015 тэмцээнд түрүүлсэн.	Д.Содномжамц нарын 6 оюутан		3 сая	2015
10	Робокон-2016 тэмцээнд түрүүлсэн.	Доржбат нарын 7 оюутан		3 сая	2016

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Зүтгүүрийн аж ахуйн төгсөх ангийн оюутнуудыг “Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуйн” талаарх 16 цагийн хичээл, сургалтыг зохион байгуулж сертификат олгосон байна.

- Сургуулийн зүгээс суралцагчийн сайн дурын клуб, үйл ажиллагааг дэмжих журам гарган хэрэгжүүлэхдээ нэг хүртэл кредитийн урамшуулал олгох сайн дурын нийтээрээ хамрагдах явган аялал, үндэсний хувцасаараа гоёх “Дээлтэй монгол” арга хэмжээ, УЗН-ээс зохион явуулдаг “Цусаа хандивлая” аян зэрэг үйл ажиллагааны зохион байгуулсан.
- Сургуулийн сургалтын хөтөлбөрт үйл ажиллагааг дэмжих чиглэлээр төсөл, хөтөлбөр, илтгэл, мэтгэлцээний уралдаан тэмцээн зэргийг жилдээ нэгээс багагүй зохион байгуулсан.
- Төмөр замын дээд сургуулийн болон Улсын, Олон улсын чанартай тэмцээн уралдаан, төсөл, хөтөлбөрт үйл ажиллагаанд амжилт гарган оролцсонг харгалзан үзэх хоёр хүртэл кредитийн урамшуулал олгох сайн дурын болон мэргэжлийн клубуудыг ажиллуулсан.
- “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төвийг Нийслэлийн хөдөлмөрийн газартай хамтран зохиосон байгуулсан.
- Жил бүр “Улаанбаатар төмөр зам”-ын Хүний нөөцийн албатай хамтарч “Төгсөгч-Ажил олгогчдын уулзалт”-ыг зохион байгуулж, төгсөх ангийн оюутнуудад үйлдвэрлэл дээр байгаа ажлын байрны санал, хэрэгцээг ажил олгогч нар танилцуулж ажилласан байна.
- БСШУСЯ-ны бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, ЗТХЯ-ын Төмөр зам, далайн захиргаа, бодлого хэрэгжүүлэх газар, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Монголын төмөр зам” ТӨХК, “Болд төмөр Ерөө гол” ХХК, Монголын төмөр замын нэгдсэн холбоо, Монголын зүтгүүрийн инженер мэргэжилтний холбоо, Монголын машинчдын холбоо, Ажил олгогч эздийн холбоо, Эрдэнэт үйлдвэр-ийн төмөр зам зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж, эдгээрийн хүний нөөцийн менежерүүдтэй уулзалт зохион байгуулж, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөгөө, мэдээллийг оюутнуудад өгч зүтгүүрийн аж ахуйн төгсөх ангийн оюутнуудыг ажлын байртай болгох чиглэлээр хамтран ажилласан байна.
- Зүтгүүрийн аж ахуйн төгсөгчдийн 90 хувь нь сургуулиа төгсөөд ажлын байраар хангагдан үйлдвэрлэлд орж ажилладаг нь онцлог давуу тал гэж үнэлэв.

Оюутаны отрядад ажиллах Зүтгүүрийн аж ахуйн ангийн төлөөлөл



5.3 дугаар зураг. 2018-2019 онд Оюутаны отрядад ажиллах нийт бүрэлдэхүүн

Анхаарах:

- Зүтгүүрийн аж ахуйн ангийн нийт оюутнуудын дунд зохион байгууллагдаж байгаа ажлуудыг сайжруулах, оюутнуудаас санал, асуулга авсны үндсэн дээр төлөвлөгөө гаргаж, нийт оюутнуудыг бүрэн хамруулахад анхаарах;
- Нийтийн оюутнуудын дунд зохион байгууллагдаж клуб, секц, дугуйлан болон бусад олон нийтин ажлууд нь сургалтын төвшин дээшлүүлэх, техник сэтгэлгээг сайжруулах, судалгааны арга зүй болон багаар ажиллах чадвар эзэмших, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эерэг хандлагыг төрүүлэх, нийгмийн сайн сайханд манлайлах, сурч боловсрох идэвхийг өрнүүлэх зөв төлөвшилтэй техникч, инженерүүдийг төрүүлэхэд түлхүү анхаарч ажиллах.

Зөвлөмж:

- Зүтгүүрийн аж ахуйн ангийн нийт оюутнуудын зохион байгуулах олон нийтийн ажил нь тэдгээрийн хүсэл, тэмүүлэлийг өрнүүлсэн, сурлага, хүмүүжил, төлөвшилтийг суулгахад чиглэгдсэн, тэдгээрийн идэвхийг өрнүүлэх замаар зохион байгуулах.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

Төмөр замын Дээд суруулийн захиралын 2018 оны 10 сарын 26 өдрийн А/190 тоот “Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-аар зүтгүүрийн ангийн оюутнуудыг хөтөлбөр хооронд болон өөр их сургуулиудаас шилжих ирэх, гадаадын зам харилцааны их, дээд сургууль болон магадлан итгэмжлэгдсэн дотоодын инженерийн чиглэлийн үндэсний их, дээд сургуулиудаас шилжиж ирэх оюутнуудын сурлагын дүнгийн голч нь 2,5 с дээш байвал хичээл дүйцүүлэлтийг хийж элсүүлэх, мөн сургуулийн бакалаврын сургалтын хөтөлбөр хооронд шилжилт хөдөлгөөн хийх, хөтөлбөрийн анги дүүргэлт, хүйсийн квотыг харьцааг үндэслэн, шилжүүлэх асуудалыг шийдвэрлэн ажилласан байна.

Зүтгүүрийн аж ахуй мэргэжлийн хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнуудын шилжилт хөдөлгөөний судалгаанаас харахад оюутнуудын шилжилт хөдөлгөөн хийхэд тэдэнд хүндрэлгүй байгаа бөгөөд хөтөлбөр хооронд шууд дүйцүүлэхээр, гадны сургуулиудаас шилжин ирэх тохиолдолд тухайн сургуулийн магадлан итгэмжлэгдсэн байдлаас хамааран дүйцүүлэхээр эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.

5.3 дүгээр хүснэгт

Зүтгүүрийн аж ахуйн хөтөлбөрөөр суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа

Суралцагчийн шилжилт хөдөлгөөн	Хичээлийн жил					Эзлэх хувь
	2018	2017	2016	2015	2014	
Улирлын чөлөө авсан	8	18	12	6	2	46
Чөлөөнөөс орж ирсэн	9	6	13	8	2	38
Сургуулиас гарсан	10	9	6	21	8	54
Шилжсэн	2	5	6	4	6	23
Цэрэгт явсан	1				1	2
Хөтөлбөр хооронд сольсон		3	3	4	9	19
Нийт	30	41	40	43	28	182

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Зүтгүүрийн аж ахуйн ангийн оюутнуудын судалгаанаас үзэхэд 2 болон 3 дугаар курсын оюутнуудын шилжилт хөдөлгөөн нь 4 болон 5 дугаар курсынхтэй харьцуулахад харьцангуй өндөр байгаа нь анги дэвших тусам шилжилт хөдөлгөөн багасаж, тогтвортой суралцаж байна.

Анхаарах:

- Зүтгүүрийн аж ахуйн ангид элсэн орсон оюутнуудыг шилжүүлэхгүй, онцгой биш шалтгаанаар чөлөө авахгүй сургуулийн хөтөлбөрийн бүрэн чанартай дүүргэх тал дээр анхаарч, зөвлөж ажиллах,

Зөвлөмж:

- ОХУ болон бусад орны Төмөр замын их, дээд сургуулиудтай 1:3, 2:3 хөтөлбөрийг хэрэгжүүлэх бол нарийвчилсан хөтөлбөрийг, судалгаа болон туршилтын үндсэн дээр эрсдэлгүй, олон оюутныг шилжих хөдөлгөөнд оруулахгүй байх талаар анхаарч ажиллах,
- Зүтгүүрийн аж ахуйн ангид шинээр шилжиж ирэх, мөн бусад их дээд сургуулиудад шилжин суралцахад хөтөлбөр, програм, кредитын хол зөрүүгээр байхын тулд хөтөлбөрийг бусад техникийн ухааны сургуулийн хөтөлбөрүүдтэй дахин хянан нягтлах.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

“Зүтгүүрийн аж ахуй” мэргэжлийн төгсөгчид төрийн болон төрийн бус байгууллагуудтай төмөр замын тээврийн багц дүрмийн шинэчлэх төсөл бичих, төсөлд санал өгөх, хөдлөх бүрэлдэхүүний техникийн шаардлага, норм стандарт боловсруулах, мөн түүнд санал өгөх, сургалт зохион байгуулах зэрэг нийт 13 төрлийн багц ажил, үйлчилгээг хамтран зохион байгуулсан нь нийгэмд үзүүлж буй үйлчилгээ тогтмолжсон, төгсөгчидтэй хамтран ажилладаг гэж үнэллээ.

“Зүтгүүрийн аж ахуй” мэргэжлийн бакалаврын хөтөлбөрөөр төгсөгчийн үндсэн баримт бичиг нь бакалаврын диплом бөгөөд оюутны эзэмшсэн мэргэжлийн нэр, суралцсан бүх хичээл, дадлага болон улсын шалгалтын үнэлгээ, голч оноо, дипломын сэдвийн нэр зэрэг үндсэн мэдээлэлүүд агуулсан байна.

“Зүтгүүрийн аж ахуй” мэргэжлийн хөтөлбөрөөр төгсөгчдийг Байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухааны үндсэн ойлголт, инженерийн суурь болон ахисан түвшний мэдлэг, аргачлал эзэмшүүлэх, хувь хүний төлөвшил, багаар ажиллах, тээврийн салбарын ажилтны сахилга, хариуцлагаа ухамсарлах чадвартай болох, техникийн асуудлуудыг тодорхойлох, хөгжүүлэх, шийдвэрлэх дадалтай болох, инженерийн шийдлийн гадаад орчин ба нийгмийн хүрээний нөлөөллийг ойлгох чадвар, удирдлагын төвшинд болон бизнесийн хүрээнд сэтгэн бодох чадвар, үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадварт хүрэх, төлөвлөжүүлэхээр ажиллаж байна.

“Зүтгүүрийн аж ахуй” мэргэжлийн хөтөлбөр дагуу төгсөгчидтэйгээ эргэх холбоотой ажиллаж тэдэнд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, зүтгүүрийн зааварлагч машинч нарын мэргэжил дээшлүүлэх курс сургалтыг гурван удаа 36 төгсөгч, зүтгүүрийн засварын мастер, хүлээн авагч нарын мэргэжил дээшлүүлэх курс сургалтыг хоёр удаа 24 төгсөгч, засварын инженер техникийн ажилчдын мэргэжил дээшлүүлэх курс сургалтыг нэг удаа 12 төгсөгч нарыг хамруулж, мэргэжил зэрэг дээшлүүлэх курс сургалтыг “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Зүтгүүрийн аж ахуйн албатай хамтран зохион байгуулсан байна. Жил бүрийн ажлын төлөвлөгөөнд энэхүү курс сургалтыг

төлөвлөн төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгааг гаргаж, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулсан байна..

Илрэл нотолгоо:

- “Зүтгүүрийн аж ахуй” мэргэжлийн бакалаврын хөтөлбөрөөр төгсөгчид сургуулийн захиргаа “Улаанбаатар төмөр зам” ХНН–ийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хэлтэстэй хамтран “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн” чиглэлээр тусгай сургалтын зохион байгуулж сертификат олгож төгсөгчид, үйлдвэр болон аж ахуй нэгж дээр очиж ажиллахдаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа мөрдөн ажиллах мэдлэг, дадлыг олгосон байна.
- Оюутнууд галт тэрэгний ирэх, буцах тасалбарыг жилд нэг удаа үнэгүй олгодог, Төмөр замын эмнэлгээр үйлчлүүлж, эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамрагддаг, “Улаанбаатар төмөр зам” ХНН–ийн даргын нэрэмжит тэтгэлэг, шагналд сургуулийн шилдэг оюутнуудыг жил бүр тодорхойлж урамшуулдаг, зөвлөх үйлчилгээ өгсөн байна.
- Жил бүр Ажил олгогч-Сургууль-Төгсөгч оюутны уулзалтыг тогтмол зохион байгуулж, төгсөх ангийн оюутнуудаас ажлын санал авч, “Улаанбаатар төмөр зам”-ын Замын даргын тушаалаар ажлын байранд хуваарилсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Зүтгүүрийн аж ахуй мэргэжлийн III-курсын оюутнууд 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн “Улаанбаатар төмөр зам” ХНН–ийн удирдлагаас өгсөн чиглэл үүргийн дагуу үйлдвэрлэлийн дадлагын дараа амжилттай сурч, дадлага хийсэн оюутнуудад зүтгүүрийн засварчны, туслах машинчийн зэргийн үнэмлэх олгох шалгалтад хамруулж, стандартын шаардлага хангасан нөхцөлд ажил олгогч, оюутанд зориулсан “Оюутны тодорхойлолт”-ын хуудсыг бакалаврын дипломтой хамт өгөхөөр шийдвэрлэсэн нь тэднийг бүтээлч, хариуцлагатай, мэргэжлийн дадал, чадвар, ёс зүйтэй төлөвшүүлж байна гэж үнэллээ.
- Зүтгүүрийн аж ахуйн төгсөгчийн суралцаж буй хугацааны судалгааны чадамж, хариуцлагатай байдал, нийгмийн идэвхи, багаар ажиллах чадвар, харилцааны чадвар, өөрийгөө хөгжүүлэх эрмэлзлэл, спорт урлагын болон бусад амжилт, хөтөлбөрөөс гадуур эзэмшсэн чадварууд зэрэг дипломын дүнгийн хавсралтанд тусгагддаггүй онцлох давуу тал, амжилт, хувь хүний чадвар, төлөвшилтийг тодорхойлон тусгах болсон байна;
- Зүтгүүрийн аж ахуйн зөвлөх багш оюутнаас “Оюутны тодорхойлолт”-ын хуудсын дагуу мэдээллийг авч дүн шинжилгээ хийж, дүгнэлт бичиж, оюутан бүрт танилцуулан хүлээлгэн өгч, гарын үсэг авч баримтжуулсан байна;
- Зүтгүүрийн аж ахуйн төгсөх оюутнуудад дипломын хавсралтай хамт дагалдуулан өгч, тус мэдээллийн санг ашиглан дүгнэлт бичиж дипломын хамт гардуулах ба энэ үйлдвэр дээр ажил олгогч ажилд томилоход чухал үнэлэмж болдог байна;
- Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шинжээчийн баг Зүтгүүрийн аж ахуй ангид суралцагчид болон төгсөгчидтэй уулзалт хийж, санал сэтгэгдлийг авахад тэдгээрийн сэтгэл хангамж өндөр байв.
- Зүтгүүрийн аж ахуйн төгсөгчид 85 хувь Татах хэсгийн-1, 2,3 хэсэгт хуваарилагдан ажиллаж, үлдсэн нь Төмөр замын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад ажиллаж байгаа салбарын эрэлтийг энэхүү хөтөлбөр нийцэж байна гэж үнэллээ.

Анхаарах:

Зүтгүүрийн аж ахуйн ангийн сургалтын хөтөлбөрөөр төгсөгчдийн баримт бичиг, номын санд байрлуулсан материалуудаас үзэхэд төгсөх оюутнуудын дипломын ажил бичих заавар, аргачлалыг техникийн үйлдвэрлэл, засвар, ашиглалт, үйлчилгээ, нормчлол,

технологи, шинэчлэлт, сайжруулалт зэрэг төрөл, чиглэл бүрээр гаргаж, шинжлэх ухааны онол арга зүйд тулгуурласан инновацид суурилсан бүтээл болох, мөн судлаачийг бэлтгэхэд чиглэхэд анхаарах зүйтэй гэж үзэж байна.

Зөвлөмж:

- Зүтгүүрийн аж ахуйн ангийн сургалтын төлөвлөгөөг боловсруулахдаа хичээлүүд хоорондоо харилцан уялдаа, залгамж холбоотой, орчин үеийн эрэлт шаардлагад нийцүүлж, оюутнуудын оюуны чадавхийг хөгжүүлэх, онол практикийн мэдлэг, чадвар, дадал эзэмших чиглэлээр хөтөлбөрийн дагуу төлөвлөгөөт хичээлүүдийг бүрэн үзэж, мэргэжлийн дадлага хийж, төгсөлтийн ажил буюу диплом бичиж хамгаалж байна. Цаашид сургалтын төгсөлтийн ажил буюу диплом бичиж хамгаалалтыг чанаржуулах, шинжлэх ухаан, суурь судалгааныг нарийвчлан хийлгэх, судлаач нарыг бэлтгэн төгсгөх, мөн дипломын ажил, судалгааг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг идэвхижүүлэхийг зөвлөж байна.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилгоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- 2012 онд боловсруулагдаж, 2015, 2018 онуудад шинэчлэгдсэн батлагдсан “ТЗДС-ийн хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт хийх журам”-ыг даган мөрддөг. 2017-2018 оны хооронд нийт 8 багш, ажилтан сонгон шалгаруулж авсан байна. Гэвч бодлогын хэрэгжилтийн тайлан энэхүү өөрийн үнэлгээний тайланд тусгагдаагүй байна.
- Сургуулийн хэмжээнд нийт багш нарын 18% докторын зэрэгтэй бол хөтөлбөрийн үндсэн 5 багшийн 20% доктор зэрэгтэй.
- Нэг багшид 32 оюутан ноогдож байна гэж үзсэн боловч сүүлийн 5 жилийн судалгаа тайланд тусгагдаагүй байна.
- “УБТЗ” ХНН-ийн Замын дагын 2018 лын А-525 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлага тодорхойлогдсон байдаг. Хөтөлбөрийн хүрээнд үндсэн 5 багш ажилладаг бөгөөд үүнээс хөтөлбөр хариуцсан дэд профессор 1, ахлах багш 3, 1 багштай. Магистрын зэрэг хамгаалаагүй 1 багш багшийн албан тушаалд ажиллаж байгаа нь багшийн зэрэглэлд тавигдах шаардлагатай нийцэхгүй байна. Гэхдээ энэ багш нь Америкт мэргэжил дээшлүүлсэн, мөн уригдаж ажиллаж байгаа, одоо 2018-2019 оны Булиралд магистр хамгаалах гэж байгаа хүндэтгэх шалтгаантайгаар багшийн орон тоонд ажиллуулж байна.
- Багшийн цагийн ачааллыг “А”-сургалт, “Б”-эрдэм шинжилгээ, инноваци, “В”-сургууль, олон нийтийн үйлчилгээ гэж үнэлдэг бөгөөд Дэд профессорын хувьд А цаг бага, Б цаг ихтэй байдаг бол Ахлах багш, багийн хувьд А цаг нэмэгдэж, Б цаг буурдаг байна. Гэхдээ цагийн ачаалал тооцсон судалгаа тайланд тусгагдаагүй байна.

- Багш нарт сарын ажлын үр дүнгийн шагнал 35-50%, жилийн ажлын үр дүнгийн шагнал 100-200% олгогддог бол УБТЗ-д тасралтгүй ажилласны нэмэгдэл 4,5-10,5% олгогддог байна. Багш нарт олгогдсон урамшууллын судалгаа тайланд тусгагдаагүй.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- УБТЗ-ын даргын 2013 оны А-152 тоот тушаал, Хөдөлмөрийн дотоод журмын 3-р зүйлийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслээд багшийн сонгон шалгаруулалт хийдэг бөгөөд сонгон шалгаруулалтын комисс шалгаруулалтанд орсон хүмүүсийн анкетыг 20 хүртэл оноогоор, мэргэжлийн түвшин тогтооох тестийг 50 хүртэл оноогоор үнэлээд, ярилцлага хийж, үлдсэн 30 онооны үнэлгээг өгдөг байна.
- Багш нарт сарын ажлын үр дүнгийн шагнал 35-50%, жилийн ажлын үр дүнгийн шагнал 100-200% олгогддог бол УБТЗ-д тасралтгүй ажилласны нэмэгдэл 4,5-10,5% олгогддог байна

Анхаарах асуудал:

- Үндсэн багшийн тоонд доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх
- Багш суралцагчдын тооны зохистой харьцааг тодорхойлдог болох
- Цаашид албан тушаалын зэрэглэл ангилалд тавигдах шаардлагыг даган мөрдөх
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа хийх, Б цаг буюу эрдэм шинжилгээ, инновацид зарцуулах цагийг багш нарт гаргаж өгөх, эрдэм шинжилгээ судалгааны өгүүллийг олон улсын чанартай эрдэм шинжилгээний хурал болон сэтгүүлүүдэд хэвлүүлэх асуудалд анхаарал хандуулах
- Багш нарт олгосон урамшууллын судалгаа хийх

Зөвлөмж:

- Сургуулийн удирдлагаас багш нарын эрдэм шинжилгээний ажил хийх нөхцлийг бүрдүүлж докторын зэрэг хамгаалахад түлхэц өгөх.
- Багшийн А, Б, В цагийн ачааллыг жигд хуваарилахаас гадна А, Б, В цагийн үнэлгээний журмыг багш нарт танилцуулж, тогтмол өөрсдөөр нь үнэлүүлж занших

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- 2030 он хүртэл ТЗДС-ийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний хүрээнд 2017-2018 оны хичээл “Багшийн хөгжил хөтөлбөр”-ийг боловсруулж, 2018-2019 оны хичээлийн жилээс батлуулан хэрэгжүүлж байна. Улмаар энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг хичээлийн жил бүр дүгнэн, түүний үр дүнд суурилсан сайжруулалтыг тогтмол хийж ажиллана. Заах арга зүйг сайжруулахын тулд багш жилд 1-2 удаа нээлттэй, үзүүлэх хичээлүүд ордог бөгөөд сүүлийн таван жилд Намрын улиралд нийт 41, Хаврын улиралд нийт 41 нээлттэй хичээл орсон байна.
- Хөтөлбөрийн багийн багш нар сургалт, судалгааны чиглэлд болон өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөтэй ажилладаг бөгөөд сар, улирал, жилээр мэргэжлийн салбарын хэмжээнд тайлагнадаг.
- Багшийг хөгжүүлж тэдний мэргэжил дээшлүүлэх, эрдмийн зэрэг хамгаалахад дэмжлэг үзүүлэхийн тулд УБТЗ-ын даргын 2018 оны 11-р сарын 14-ны өдрийн А525 тоот тушаалыг даган мөрддөг. 4 багшийг нийт 30 сургалтанд хамруулснаас багшлах эрхийн сургалтд 3 багш, хэлний сургалтанд 2 багш 3 удаа, мэргэжил дээшлүүлэх 19

сургалтанд 4 багш, CDIO арга зүйн сургалтанд 1 багш тус тус хамрагдсан байна. Мөн 1 багш магистрын зэргийн сургалтанд суусан бол мэргэшсэн инженерийн сургалтанд 2 багш, зөвлөх инженерийн сургалтанд 1 багш тус тус суусан байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн багийн багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр мэргэжил дээшлүүлэх курс, семинарт хамруулахад дэмжлэг үзүүлдэгээс гадна 2017 оны 11-р сарын 16-ний өдөр батлагдсан УБТК-ын даргын А-449, 2018 оны 11-р сарын 14-ний өдөр батлагдсан А-525 тушаалаар “Докторын сургалтанд хамрагдахад тэтгэлэг чөлөө олгох журам”-ын дагуу дараах хөнгөлөлтүүдийг үзүүлдэг байна. Үүнд:
 - Докторын сургалтын танхимын цагийн 50 хүртэлх хувь, судалгааны ажлын 75 хүртэлх хувьтай тэнцэх төлбөрийн тэтгэлгийг суралцах хугацаанд олгох;
 - Мэргэжлийн нэгдсэн шалгалт өгөх үед тухайн докторантыг суралцах хугацаанд 2 удаа үндсэн ажлаас нь ажлын 10 хоногийн хугацаанд цалинтай чөлөө олгох;
 - Диссертаци бичих, хамгаалах үед тухайн докторантанд суралцах хугацаанд нэг удаа үндсэн цалинтай 2 хүртэлх сарын бүтээлийн чөлөө тус тус олгох;
 - УБТЗ ХХН-ийн бус зардлаар болон хувиараа гадаадын их сургуульд өдөр, эчнээ хэлбээр суралцдаг докторантад:
 - Гадаадын их сургуульд өдрийн ангил суралцдаг докторантад хичээлийн жилд 1 удаа ирж очих замын зардал;
 - Гадаадын их сургуульд эчнээ хэлбэрээр суралцдаг докторантад мэргэжлийн нэгдсэн шалгалт өгөх үед 1 сарын, диссертаци хамгаалах үед 3 хүртэлх сарын үндсэн цалинтай бүтээлийн чөлөөг тус тус суралцах хугацаанд нэг удаа олгох буюу ирж, очих замын зардал олгоно гэж тус тус заажээ.

Анхаарах асуудал:

- Багшийн судалгааны ур чадварыг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах, бусад сургуулийн эрдэмтэн багш нартай хамтарсан бүтээл туурвих үйл ажиллагааны эхлэлийг тавих.

Зөвлөмж:

- Докторын сургалтанд хамрагдахаар хөнгөлөлт эдэлсэн багш нарын үр дүнг дүгнэх
- Гадаад дотоодод төсөл, хөтөлбөр, сургалт семинарт хамрагдсан багш нарын сургалт, судалгаа, шинжилгээний ажилд ямар үр дүн, ахиц дэвшил бий болж байгааг дүгнэх

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- 1 ашигтай загварын гэрчилгээтэй.
- Багшийн ачаалалд заагдсан “Б” цагийн дагуу багш нар судалгаа шинжилгээний ажлын 4-9кв гүйцэтгэх ёстой бөгөөд үндсэн 5 багшийн судалгааны ажлын чиглэлийг тайланд тусгасан боловч багш нарын оролцсон захиалгат төсөл, судалгаа, гэрээт ажлын талаарх мэдээлэл тайланд тусгагдаагүй.
- Үндэсний болон олон улсын нэр хүнд бүхий хэвлэлд багш судлаачдын бүтээлийг хэвлүүлэх чиглэлээр баримталдаг бодлого болон үзүүлдэг дэмжлэг тайланд тусгагдаагүй. Хөтөлбөрийн багш нар 2006-2017 оны хооронд нийт 19 эрдэм

шинжилгээний бүтээл хийсэн гэж тайлагнасан ч хэд нь зөвхөн олон улсын болон улс, их сургуулийн түвшний хуралд хэлэлцэгдсэн, хэд нь олон улсын болон улс, их сургуулийн түвшний хурлын эмхэтгэлд хэвлэгдсэн, хэд нь олон улсын болон үндэсний нэр хүнд бүхий сэтгүүлд хэвлэгдэн эшлэл татагдсан нь тодорхой бус байна. Багш нарын хэвлүүлсэн сурах бичиг, ном, гарын авлага болон гадаад, дотоодод эшлэл татагдсан эрдэм шинжилгээний бүтээлийн талаарх мэдээлэл тайланд тусгагдаагүй.

- Докторын сургалтанд хамрагдаж байгаа багш нарт зарцуулсан болон зарцуулахаар төлөвлөсөн төсөв тайланд тусгагдсан боловч бусад эрдэм шинжилгээ, судалгааны ажилд төсвийг хэрхэн бүрдүүлж, зарцуулж байгаа нь тайланд тусгагдаагүй. “Докторын сургалтанд хамрагдахад тэтгэлэг чөлөө олгох журам”-ын дагуу 2018 онд багш нар 23,7 сая төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн бол 2019 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд 17,4 сая төгрөгийн хөнгөлөлт, олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцоход 23 сая төгрөг, мэргэжил дээшлүүлэхэд 2 сая төгрөг зарцуулахаар тусгагдсан байна. Зүтгүүрийн аж ахуй хөтөлбөрийн мэргэжлийн багш нарын хувьд 4,5 сая төгрөгийн хөнгөлөлтийг эдэлсэн бөгөөд 2019 онд 2,1 сая төгрөгийн хөнгөлөлт эдлэхээр төлөвлөгөөнд тусгагдсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Зүтгүүрийн аж ахуй мэргэжлийн хөтөлбөрийн мэргэжлийн багш нар “2ТЭ-116Ум илчит тэрэгний цахилгаан тоноглол, жолоодлого”-ын сургалтын тренажёр зохион бүтээж МУ-ын Оюуны өмчийн газраас шинэ бүтээл ашигтай загварын гэрчилгээ авсан.

Анхаарах асуудал:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентын тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах
- Эрдэм шинжилгээ, судалгаа ажлыг сургуулиас бодлогоор дэмжиж олон улсын, улсын чанартай эрдэм шинжилгээний хуралд багш нарыг өргөнөөр оролцуулах, мөн олон улсын сэтгүүлүүдэд өгүүлэл хэвлүүлэхэд нь түлхэц өгөх
- Багш нарыг ордог хичээлүүдийнхээ хүрээнд ном, гарын авлага гаргах ажлыг эрчимжүүлэх.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- 2018 оны 12-р сарын 25-ны өдрийн А/240 тоот тушаалын дагуу ТЗДС-ын хөтөлбөрийн чанарын үнэлгээний журмаар багшийн үйл ажиллагааг мэдлэг оюуны чадамж, хувь хүний чадамж, судалгааны чадамж, сургахуйн чадамж гэсэн дөрвөн үзүүлэлтээр багш өөрийгөө үнэлдэг. Багшийн өөрийн үнэлгээний тайланг сар, улирал, жилээр авдаг гэсэн боловч үнэлэх дүгнэх журам тодорхой бус.
- 2019 оны 1-р сард хөтөлбөрийн үндсэн 4 багш болон 1 гэрээт багшийн хөгжил, чадамжийн хүрээг Vitae researcher development framework загварын жишиг асуултуудаар үнэлж үзсэн. Энэ үнэлгээгээр үндсэн 4 багшийн мэдлэг оюуны чадамж 1,37-3 хүртэл оноогоор үнэлэгдсэн бол хувь хүний чадамж 4,5-4,8 хүртэл оноогоор үнэлэгдсэн, сургахуйн чадамж 2,5-3,8 хүртэл оноогоор үнэлэгдсэн байна. Харин судалгааны чадамжийн 4 үзүүлэлтүүдийн хувьд багшийн өөрийн үнэлгээ 2 буюу дундаас доогуур түвшинд байхад нэгдсэн үнэлгээ нь 4-5 гэж тодорхойлогдсон нь үнэлгээний арга зүйг багш ойлгож үнэлээгүйг харуулж байна.

- Хөндлөнгийн үнэлгээг өөрийн үнэлгээний 4 үзүүлэлтээр сургууль болон салбар/тэнхимийн удирдлагаас багшийг, хөтөлбөрт оролцогч багш багшаа, хөтөлбөрөөр суралцагч оюутан багшаа, төгсөгч нь багшаа үнэлдэг гэж тодорхойлсон байгаа хэдий ч хөндлөнгийн үнэлгээний арга зүй ойлгомжгүй. Зөвхөн байгаль-нийгмийн ухааны тэнхимийн багш нарыг орж байсан болон ордог ангийн оюутнуудаас түүвэрлэн 1035 оюутнаар хувь хүний чадамж болон сургахуйн чадамжийг үнэлүүлсэн үр дүнг тайланд тусгажээ.
- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайлан мэдээ энд тусгагдаагүй.
- Багшийн хавтасанд орох ёстой баримт бичгийн жагсаалтын талаар тайланд тусгагдаагүй. Багш нар хавтас бүрдүүлдэг эсэх талаар ч тусгагдаагүй байна. ТЗДС дээр ажиллаж тайлангийн нотлох бичиг баримттай танилцах үед зарим багш нарын хавтастай танилцсан. Хавсанд багшийн анкет, эрдмийн зэрэг хамгаалсан диплом, сургалтанд суусан сертификатууд байснаас гадна шагнал урамшуулалтай холбоотой баримтуудын хуулбарууд бас байсан. Мөн хичээлийн файл бүрдүүлэлт хийгдсэн байсан.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Анхаарах асуудал:

- Багшийн өөрийн үнэлгээ хийж дүгнэх журамд тусгагдсан үзүүлэлтүүдээр багшийн өөрийн үнэлгээний тайланг тогтмол авч үр дүнг үнэлж хэвшүүлэх
- Багшийн хөндлөнгийн үнэлгээг мөн тогтмол хугацаанд хийж хэвшүүлэхээс гадна үр дүнг багшид танилцуулж, сайжруулах төлөвлөгөө гарган ажилладаг болгох
- Сургалтанд оролцогчид UNIMIS системээр дамжуулан багшийн ажлыг үнэлдэг системийг хөгжүүлэн ашигладаг болох
- Багшийн хавтсанд ажлын төлөвлөгөө болон тайланг оруулж, төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавьдаг болох

Зөвлөмж:

- Vitae researcher development framework загвараар багшийн хөгжлийн түвшин, чансааг илэрхийлэх онооны утгыг ойлгомжтой тайлбарлаж багш нарт өөрийн үнэлгээ хийх талаар зөвлөмж өгөх

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

ШАЛГУУР 7. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангаж, сонирхогч талуудын эрэлтэд нийцсэн, үнэ цэнэтэй байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схемтэй
- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөг гаргасан байна.

- Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудаас судалгаа авсан байна.
- 2012 онд байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих нэгжийг анх байгуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ТЗДС-ийн захирлын 2018 оны А-191 тоот тушаалаар “Сургалтын чанарын дотоод баталгаажилтын баг” байгуулсан.
- ТЗДС-ийн захирлын 2018 оны А-240 тоот тушаалаар “ТЗДС-ийн хөтөлбөрийн чанарын үнэлгээний журам, Чанарын дотоод баталгаажилтын багийн ажиллах журам” тус тус баталсан.
- ТЗДС-ийн чанарын менежментийн тогтолцооны зураглал гаргасан байна.
- Дотоод чанарын батгаажилтын ажлыг хөтөлбөрийн ахлах багш удирдан хяналт тавин ажилладаг.
- Сургуульд сургалтын дотоод хяналтын мэргэжилтэн дотоод чанарын баталгаажуулалтын ажлыг хариуцан ажилладаг.

Анхаарах асуудал:

- Сургуулийн Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын баг 2018 онд байгуулагдсан бөгөөд үйл ажиллагаа нь төлөвшөөгүй, цаашид хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хийхээр тусгасан.
- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалт хийх үе шаттай нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх
- Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг мөшгиж хянасан байдал хангалтгүй.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор хийсэн судалгааны үр дүнд үндэслэн гарсан чанарыг сайжруулах үйл ажиллагааг холбогдох төлөвлөгөөнд тусгах эсвэл бие даасан төлөвлөгөө гаргаж хэвших
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгжийн чанарын баталгаажилтын талаарх мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх

7.2 Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- Сүүлийн 3 жилийн хугацаанд 104 оюутны хөдөлмөр эрхлэлтийн судалгаагаар 66 төгсөгч буюу 63,4% нь эзмэшсэн мэргэжлээр УБТЗ-ын татах хэсгүүдэд, 21 төгсөгч буюу 20,2% нь мэргэжлийн салбарт, 14 төгсөгч буюу 13,4% нь ахисан түвшинд суралцаж, 3 төгсөгч ажил хүлээж байна.
- Төгсөгчид ажлын байранд нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийх зорилгоор сүүлийн 3 жилд сэтгэл ханамжийн судалгаа 2 удаа, хөтөлбөрийн хэлэлцүүлэг 3 удаа хийсэн гэдгийг нотлох баримт хавсрагдаагүй байна.
- Төгсөх ангийн оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгааг тодорхой гаргаагүй байна.

Зөвлөмж:

- Төгсөгчдийг мөшгөх судалгаа, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааг тогтмолжуулан, эргэх холбоог хангах

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Төмөр замын дээд сургууль нь 2001, 2006, 2018 онуудад БМИҮЗ-ийн дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлд тэнцсэн байна.
- Тус хөтөлбөрөөр суралцагчийн хамтарсан хөтөлбөр оюутан солилцоонд хамрагдах бүрэн боломжтой бэлтгэл ажлыг хангасан байна.
- Тус хөтөлбөрөөр төгсөгчидөөс БНХАУ, Австрали, АНУ, ОХУ-д 14 оюутан ахисан түвшний сургалтанд хамрагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тус хөтөлбөрөөр төгсөх ангийн оюутнуудын бакалаврын зэрэг хамгаалах төгсөлтийн ажлын үеэр ажил олгогчид өөрсдийн санаачлагын дагуу ирж, төгсөлтийн ажилтай танилцах, чадварлаг төгсөгчдөд шууд ажлын байр санал болгодог байна.
- Тус хөтөлбөрөөр төгсөгчдөөс 12 хүн хөдөлмөрийн баатар, 12 хүн гавьяат тээвэрчин болсон байна.
- 2013 оноос хойш тасралтгүй оюутнуудыг бэлдэж улсын олимпиад, уралдаан тэмцээнд амжилттай оролцуулсан байна.

Анхаарах асуудал:

- Тус хөтөлбөрт суралцаж байгаа гадаад оюутан байхгүй байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрт мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагаар үнэлгээ хийлгэх.
- Багш, оюутнуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
- Бусад улстай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх /2+2, 2+3 г.м/

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	Бүрэн хангасан			
2	Сургалтын үйл ажиллагаа	Бүрэн хангасан			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	Бүрэн хангасан			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	Бүрэн хангасан			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	Бүрэн хангасан			
6	Багшийн үйл ажиллагаа		Хэсэгчлэн хангасан		<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрт мэргэжлийн хичээл ордог үндсэн багш нарт докторын зэрэгтэй багш байхгүй. • Бакалаврын зэрэгтэй багш ажиллаж байгаа нь Багшийн албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлагыг хангахгүй байна. • Багш нар эрдэм шинжилгээ судалгааны ажил хийж үндэсний болон олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний хуралд оролцож, сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх нь дутагдалтай • Багшийн үнэлгээний систем дутагдалтай байна
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	Бүрэн хангасан			
Дүгнэлт		БҮРЭН ХАНГАСАН			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Төмөр замын дээд сургуулийн “ЗҮТГҮҮРИЙН АЖ АХУЙ” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “**ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН**” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Үйлчилгээний чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/ Д.Баатархүү /

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../ С.Ариунбаяр /

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../ Т.Мөнхцэцэг /

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагыг гаргахдаа төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого, засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгцээт мэргэжилтний тоон үзүүлэлтэд шинжилгээ хийж, цаашдын чиг хандлагыг тодорхой гаргах.
2. Үр дүнд суурилсан CDIO арга зүйг хөтөлбөрт ордог багш нарт сайтар ойлгуулах, идэвхтэй сургалтын аргуудыг нэвтрүүлж, эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг сургалтын арга зүйд тохирсон аргаар үнэлэх.
3. Хөтөлбөрийн хүрэх үр дүнг (PLO) хөтөлбөрийн багаараа дахин нягталж боловсруулаад аль хичээлээр ямар мэдлэг чадвар олгохыг дахин хэлэлцэж, семинар болон лабораторийн хичээлийн сэдэв, агуулга бүртэй уялдуулах.
4. E-Cloud UNIMIS системээ ашиглан суралцагчдын үнэлгээний дүн шинжилгээг хичээл нэг бүрээр тогтмол хийдэг болох, суралцагчдын үнэлгээнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодруулах, суралцагчийн голч дүнг өсгөх, сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл боловсруулалт, нэгдсэн дүгнэлтийг тогтмол хийж занших.
5. Мэргэжлийн хичээлийн анги, танхим, мэргэжлийн лабораториуд, сургалтанд ашиглагдаж байгаа компьютер, судалгаа сургалтын полигон зэрэг оюутнууд ажиллах хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа, аргачлал, заавар, гарын авлага зэргийг сайжруулах.
6. Номын сангийн шаардлагатай, нарийн мэргэжлийн болон шинжлэх ухааны бүтээлийн ном, сурах бичгийн тоо, төрлийг нэмэгдүүлж, хангамжийг сайжруулж, баяжилтыг хийж, тэдгээрийг судлуулах ажлыг эрчимжүүлэх.
7. Хөтөлбөрт оролцогч болон сонирхогч талуудаас гарсан санал асуулгын дүнгийн дагуу хийсэн ажлыг тодорхой тусгаж, эргэж тайлагнадаг байх.
8. Оюутны техник сэтгэлгээ, харилцааны ур чадвар, судалгаа шинжингээний ажил хийхийг хөгжүүлж, судлаач оюутнуудыг төрүүлэх.
9. Оюутнуудыг улсын болон олон улсын хэмжээнд зохион байгуулагддаг эрдэм шинжилгээний хурал, олимпиад, уралдаан тэмцээнд идэвхитэй оролцуулж амжилтыг ахиулах ажлыг тогтмол зохион байгуулах, зөвлөх, удирдах, хамтран ажиллах.
10. Сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах.
11. “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн харъяа сургууль учраас төмөр замын тээврийн орлогоос татаас авдаг нь санхүүгийн хүндрэлд орохгүйгээр, оюутны тоог бус сургалтын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд анхаарах сургуулийн давуу тал боловч хөтөлбөр цаашдаа өөрийгөө санхүүжүүлдэг болоход анхаарч ажиллах.
12. Олон улсын төмөр замын болон техникийн их сургуулиудтай багш болон оюутнуудын туршлага судлах, сургалт арга зүй, судалгааны материалыг солилцох, баяжуулах ажлыг чанаржуулах, эрчимжүүлэх, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх /2+2, 2+3 г.м/.
13. Сургуулийн удирдлагаас багш нарын эрдэм шинжилгээний ажил хийх нөхцлийг бүрдүүлж докторын зэрэг хамгаалахад түлхэц өгөх. Докторын сургалтанд хамрагдахаар хөнгөлөлт эдэлсэн багш нарын ажлын үр дүнг дүгнэх.
14. Мэргэжлийн багш нарын хичээлд хэрэглэгдэх ном, сурах бичиг, гарын авлага боловсруулж гаргах идэвхийг өрнүүлэх, түүнд сургуулиас дэмжлэг үзүүлэх.

15. Багшийн А, Б, В цагийн ачааллыг жигд хуваарилахаас гадна А, Б, В цагийн үнэлгээний журмыг багш нарт танилцуулж, тогтмол өөрсдөөр нь үнэлүүлж хэвших
16. Судалгаа шинжилгээ, төсөл, хөтөлбөрөөс гарсан үр дүнг олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүнд бүхий сэтгүүлд хэвлэн нийтлүүлэх
17. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгжийн чанарын баталгаажилтын талаарх мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх
18. Хөтөлбөрт мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагаар үнэлгээ хийлгэх.

IV. ЯРИЛЦЛАГАД ОРОЛЦОГЧДЫН НЭРС

I. Багш нарын нэрс

№	Овог нэрс	Албан тушаал	Заадаг хичээл	Утас	Гарын үсэг
Суурь боловсролын тэнхим					
1	Н.Сарантуяа /Ph.D/	Тэнхимийн эрхлэгч	Физик	88090069	
2	Д.Энхтуяа /Sc.D/	Ахлах багш	Хими	99199111	
3	С.Ариунболд /Ph.D/	Ахлах багш	Хий шингэний хөтлүүр Машин механизмын онол Онолын механик	95155180	
4	Р.Содномцэрэн /Ph.D/	Ахлах багш	Хүний хөгжил, харилцааны ёс зүй	88079907	
5	Д.Бүдсүрэн /Ph.D/	Ахлах багш	Монголын түүх, соёл, ёс заншил	96667242	
6	П.Бямбахорол /Ph.D/	Ахлах багш	Монгол хэл, бичиг, найруулга зүй	88112421	
7	Э.Пүрэвдалай /Ph.D/	Ахлах багш	Цахилгаан техник	99210811	
8	М.Энхбаяр	Ахлах багш	Эдийн засгийн онол	99090937	
9	Б.Танхилсайхан	Дадлагажигч багш	Физик	99751607	
10	Д.Номинчулуун	Багш	Математик 2	99076160	
11	Д.Алтанцэцэг	Ахлах багш	Монголын түүх, соёл, ёс заншил Сэтгэлгээний түүх соёл	99254084	
12	Г.Золчимэг	Ахлах багш	Биеийн тамир	99183858	
13	Ма.Бямбасүрэн	Багш	Математик 1	99064945	
14	Ц.Хувьзаяа	Дадлагажигч багш	Техникийн зураг зүй, Дүрслэх геометр	99235239	
15	О.Жамъян	Дадлагажигч багш	Техникийн хэмжил зүй ба харилцан солилцол, Материал судлал	99002389	
16	П.Наранхишиг	Ахлах багш	Техникийн зураг зүй, Дүрслэх геометр	99847701	
17	Б.Баасанням	Ахлах багш	Алгоритм програмчлалын үндэс	99835961	

18	П.Баттөгс	Багш	Техникийн зураг зүй CAD Техникийн оношлол	88054319	
19	Ч.Нямбаяр	Дадлагажигч багш	Хийцийн материал боловсруулах технологи	88089979	
20	Д.Чулуунцэцэг	Багш	Микроконтроллёрын програмчлал Ассемблер хэл Програмчлалын хэл Мэдээллийн технологи	99235981	
21	С.Ерөөлт		Секц, дугуйлан	99944991	
22	Ц.Золзаяа	Хичээлийн туслах ажилтан	-	86118268	
Хэл соёлын тэнхим					
23	Н.Одгэрэл	Тэнхимийн эрхлэгч	Англи хэл	88177187	
24	Х.Цацрал	Ахлах багш	Англи хэл	99284626	
25	Б.Дөлгөөнжаргал	Ахлах багш	Англи хэл	99140372	
26	Б.Татьяна	Багш	Орос хэл	88558803	
27	Б.Сувд-Эрдэнэ	Багш	Орос хэл	99968420	
28	Б.Баяржаргал	Багш	Орос хэл	88008827	
Зочин багш					
29	Ли рунг	Багш	БНХАУ-ын Бугатын төмөр замын мэргэжил технологийн коллежид Барилгын багш		
30	Хао Жинг	Багш	БНХАУ-ын Бугатын төмөр замын мэргэжил технологийн коллежид Туннелийн бүтээн байгуулалт, засвар үйлчилгээ	80135504	
Зүтгүүрийн аж ахуй хөтөлбөрийн мэргэжлийн багш нар					
31	М.Бямбасүрэн	Ахлах багш	Зүтгүүрийн найдваржилт	99008442	
32	С.Галбадрах	Ахлах багш	Зүтгүүрийн татах онол, Дотоод шаталтын хөдөлгүүр	91009193	
33	М.Жаргалсайхан	Багш	Зүтгүүрийн цахилгаан тоноглол, Зүтгүүрийн динамик	88285078	
34	Б.Мягмар	Ахлах багш	Автотоормос, Зүтгүүрийн аж ахуй	99057393	
35	Д.Наранболд	Багш	Зүтгүүрийн бүтэц, Зүтгүүрийн автоматжуулалт	88050084	
Ажилтан					

31	Х.Оксана	Гадаад харилцааны мэргэжилтэн		88050219	
32	Б.Энахжаргал	Сургалтын албаны мэргэжилтэн		99866667	

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
			Орон нутгийн, Дотуур байранд амьдардаг гэх мэт
1	Г.Энхбилгүүн	Т-1	Нийгмийн идэвх сайн
2	Б.Энхням	Т-1	Онц сурдаг
3	Б.Цэрэндагва	Т-1	Ангийн дарга
4	Н.Үнэнбат	Т-1	Дотуур байранд амьдардаг
5	Д.Маналжав	Т-1	Дотуур байранд амьдардаг
6	Г.Наранхүү	Т-2	Орон нутгаас суралцаж байгаа
7	Б.Сундуйдэлгэр	Т-2	АХБ-ийн төсөлд шалгарсан
8	Г.Энхмандах	Т-2	Спортын амжилт гаргасан
9	Б.Батбилэг	Т-3	Онц сурдаг
10	А.Жаргалмөнх	Т-3	Олимпиадад амжилт гаргасан
11	С.Соронзонболд	Т-3	Нийгмийн идэвх сайтай

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага, албан тушаал
1	Б.Гантөмөр	Зүтгүүрийн аж ахуйн албаны Ашиглалт хариуцсан орлогч дарга
2	Д.Түвшинбаяр	Зүтгүүрийн аж ахуйн албаны Засвар хариуцсан орлогч дарга
3	Л.Ганбаатар	Зүтгүүрийн аж ахуйн албаны Ерөнхий инженер
4	Л.Дагвадорж	Зүтгүүрийн аж ахуйн албаны Засварын хэлтсийн дарга
5	Ц.Мэндбаяр	Зүтгүүрийн аж ахуйн албаны Сургалтын инженер

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал
1	Э.Эрдэнэхүү	2018	ТЧ-2 ашиглалтын цех туслах машинч
2	Л.Цээлхасүрэнжав	2018	ТЧ-2 цахилгаан машины цехийн засвар
3	Т.Будхүү	2018	ТЧ-2 ашиглалтын цех туслах машинч
4	Б.Оргил	2017	ТЧ-2 Дизелийн цехийн мастер

5	С.Энхболд	2017	ТЧ-2 ашиглалтын цех туслах машинч
6	Т.Мэндбаяр	2016	ТЧ-2 Дизелийн цехийн мастер засварчин
7	Б.Нямбат	2018	ТЧ-2 Түлш шүүрийн цехийн засварчин
8	Г.Лхагважав	2018	Дагалдан
9	Ч.Доржбат	2016	ТЧ-2 туслах тоноглол цехийн бригад
10	Э.Тэмүүжин	2016	ТЧ-2 өргөх цехийн мастер
11	С.Амаржаргал	2016	ТЧ-2 ашиглалтын цех туслах машинч
12	М.Азмөнх	2016	ТЧ-2 ашиглалтын цех туслах машинч
13	Х.Галбадрах	2016	ТЧ-2 ашиглалтын цех туслах машинч
14	С.Зэстэлмэн	2016	ТЧ-2 ашиглалтын цех туслах машинч

V. ХӨТӨЛБӨРИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ БАГААС ИРСЭН САНАЛ



УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ ТӨМӨР ЗАМЫН ДЭЭД СУРГУУЛЬ

210535 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 44, Утас: 24-22-60, Факс: 24-22-70
E-mail: info@insttrans.mn

2019.05.28 № 42/345
танай _____-ны № _____-г

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Хариу хүргүүлэх тухай

2019 оны 05 дугаар сарын 02, 03-ны өдрүүдэд БМИҮЗ-ийн шинжээчийн баг /ахлагч Д.Баатархүү, гишүүд С.Ариунбаяр, Т.Мөнхцэцэг нар/ ТЗДС-ийн “Зүтгүүрийн аж ахуй”-н мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийж, бодит байдал дээрх сургалтын үйл ажиллагаатай танилцаж ажилласан.

2019 оны 05 дугаар сарын 20-ны өдөр ирүүлсэн “Шинжээчийн тайлан”-г хүлээн авч, уншиж танилцлаа. Шинжээчийн багийн гаргасан дүгнэлт, тайланд тусгагдсан анхаарах асуудлууд, өгсөн зөвлөмжүүдийг хүлээн авч байна. Цаашид зөвлөмжийн дагуу сайжруулах чиглэлийн ажлуудыг шат дараатайгаар хийх болно.

Сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэх ажилд хамтран ажиллаж, үнэтэй зөвлөгөө өгч, сургалтын үйл ажиллагааг сайжруулахад сэтгэл гарган ажилласан та бүхэнд талархсанаа илэрхийлье.

Хавсралт: 1 хуудастай.

ЗАХИРАЛ



Ж.ПҮРЭВСҮРЭН

000315



Тайлбар оруулах тодотголыг дараах хүснэгтээр харуулав.

Шалгуур	Анхаарах асуудал / шинжээчээс /	Санал /хөтөлбөрийн багаас/
2.1	Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт хоорондын хамаарлыг харуулсан сургалтын төлөвлөгөөний матрицад үзүүлсэн тухайн хичээлийн сурагчид олгох мэдлэг чадвар нь багш нарын бэлдсэн хичээлийн төлөвлөгөөнд тусгагдсанаас ялгаатай байна.	Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан, хичээлийн хөтөлбөрийн хооронд зөрүүтэй мэдээлэл нь шивэх үеийн редакцийн алдаа байсан тул засварласан.
7.1	Сургуулийн Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын алба дөнгөж байгуулагдсан бөгөөд үйл ажиллагаа нь төлөвшөөгүй, цаашид хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хийхээр тусгасан.	ТЗДС-д чанарын баталгаажуулалтын алба гэж байхгүй бөгөөд Сургалтын дотоод хяналт хариуцсан нэг мэргэжилтэнтэй. 2016.08.30 өдрөөс энэ орон тоо батлагдсан хэдий ч өмнө нь ажиллаж байсан 2 хүн нь сургалтын чиглэлийн бус, шинэ хүмүүс байсан тул үр дүн хангалтгүй байсан. 2018.01.01 өдрөөс сургалтын менежер байсан багш маань энэ орон тоон дээр ажиллаж эхэлсэн. Сургуульд чанарын баталгаажуулалтын орон тооны бус нэгжтэй бөгөөд бүрэлдэхүүнд хөтөлбөр бүрээс нэг ахлах багшийг оролцуулж, 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр энэ хичээлийн жилээс эхлэн ажиллаж эхэлсэн нь өнгөрсөн онд шинээр үүсгэгдсэн гэж ойлгогджээ.
7.3	2013 оноос хойш тасралтгүй оюутнуудыг бэлдэж улсын олимпиад, уралдаан тэмцээнд амжилттай оролцуулсан байна.	Улсын олимпиад, уралдаан тэмцээний судалгаа нь 2013 оноос хойшхи байдлаар хийгдсэн тул 2013 оноос амжилт гарч эхэлсэн мэт ташаа ойлгогдсон байна.

ҮІ. МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭР

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)

[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮІІ. МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ КОМИССЫН ШИЙДВЭР

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)

[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/